



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.26 № 31-1/57
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Хүндэтгэсэн,



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.УЧРАЛ

000264001378



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.14 № МН/1623

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ^{МН}/хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265004434

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦСЭН нь: Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хооронд 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

ГАРЫН ҮСЭГ



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.05.07 № 1/2348

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА**

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.



С.АМАРСАЙХАН

ХЗДХЯ-ны А5
152640902

پسرنیج ایچیر مر سمن کمن •
 مومشوق نیک مر ایچیر




سرسر مر سمن مر ۷ همتن وکتن • وه • مکتفوق مر سمن ۸/۴ •
 عدرن سمن سرتن • هیتسوتسمن سمر • 15160
 مقسوق : (976-51) 26 75 33 • هت : (976) 26 75 33
 عدرن سمن : info@mojha.gov.ir •
 عدرن سمن : www.mojha.gov.ir

۲۰۳۳/۱۰ همتن ۲۰۴۰۱۱۶۲۰۲
 سمر و همتن و

پسرنیج ایچیر مر ایچیر • سسر مر
 سمن مر نیک مخریج سمن مر
 سمنزا و سرتوکن سزا

سمنزا کدر وکنتمهیزا کدر سرفو کدر سکنسشر و سمن پسرنیج
 ایچیر و سمر و سرفو سکنسرفو سکر ایچیر سمنسرفو کدر سسرتن • - ک
 سمنسسر و سمن سمن کدر سمن ن سمن سمنسرفو کدر سمن
 سمن کدر ۵ همتن سمن مر ۲۰۵۰ کدر سمن سق کسسر و سمن ایچیر
 مر کدر سمن سرفو سرفو کدر سمنسرفو...



151602096



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,

Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025.04.08 № 01/2934

танай _____-ны № _____-т

□ ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН □
САЙД С.АМАРСАЙХАН ТАНАА

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



З.МЭНДСАЙХАН

9761000485



**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД**

Энхтайвны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 262135, Факс: (976-11)322127
Цахим шуудан: info@mfa.gov.mn
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2026.05.01 № 01/2070

танай 2026.04.20 -ны № 1/1897. -т

**Г ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН Г
САЙД С.АМАРСАЙХАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр хүргүүлэв.



Гадаад харилцааны яам
Удирдлага
Гадаад харилцааны сайд
Батмөнх БАТЦЭЦЭГ
2026-05-01 18:00:50

БАТЛАВ.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Б.ЭНХБАЯР**

БАТЛАВ.

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
Б.БАТЦЭЦЭГ**

2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

1. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх)-ийн 7.2 дахь хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:” гээд 7.2.4 дэх заалтад “... Хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх” гэж, мөн хуулийн 25 дугаар зүйл (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засгийн газрын бүрэн эрх)-ийн 25.1 дэх хэсэгт “Засгийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 25.1.9 дэх заалтад “... Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэргэшсэн нэгж, мэргэжилтэн бэлтгэх” гэж тус тус заасан.

Мөн Эрүүгийн хуулийн 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн гадаад улсад энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана.” гэж заажээ.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу

гүйцэтгэнэ.” гэж, 42.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ.” гэж тус тус заасан.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр” нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасан эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээ тул Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ юм.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэлийг удирдлага болгон 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо гарын үсэг зурсан “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулна.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Дэлхийн улс орнууд даяаршиж, нэгдмэл болохын хэрээр аюул занал ч мөн нийтлэг шинж чанартай болж байгаатай холбогдуулан ихэнх улс орон бүс нутгийн аюулгүй байдлыг хамтран хамгаалах тогтолцоог бий болгоход илүүтэй анхаарч байна.

Гадаад улс орнуудад үндэстэн дамнасан зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн үйлдлийн арга, зохион байгуулалтын хэлбэрийг илрүүлэх, таслан зогсооход хүндрэл учирч байгаагийн зэрэгцээ нэг улсын хил хязгаараас давж, улс орон дамжин үйлдэгдэх хандлага нэмэгдэж байгаа нь хэд хэдэн улсын цагдаагийн байгууллага хамтран гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэрэгцээ, шаардлага бий болсоор байна.

Мөн манай улсын иргэдийн гадаад улсад зорчих тоо жил ирэх тусам өсөж байгаатай холбоотойгоор гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнчлэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөх, аливаа хэлбэрээр эд хөрөнгөд нь хохирол учрах явдал нэмэгдсээр байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 238, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 388 бүртгэгдсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд тухайн төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр бүс нутгийн төдийгүй олон улсын цагдаа, хууль сахиулах байгууллагуудтай түргэн, шуурхай хамтран ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Мөн цахим орчинд үйлдэгдэж буй хууль бус мөрийтэй тоглоом, залилан мэхлэх, садар самууныг сурталчлах, хүн худалдаалах зэрэг гэмт хэргүүд зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт, насанд хүрээгүй хохирогчдын тоо жил бүр өсөн нэмэгдэж байгаагийн зэрэгцээ зүүн Европын орнууд болох Албани, Серби зэрэг улсын гэмт бүлэглэлүүдийн үйлдлийн арга, хэлбэртэй төстэйгээр үйлдэгдэж байгаа нь Чех Улстай энэ чиглэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгцээг илэрхийлж байгаа юм.

Иймд “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Чех Улсаар дамжин Европын холбооны 27 улсад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүднээс шуурхай мэдээлэл солилцох, хамтран ажиллахад чухал ач холбогдолтой хэлэлцээр гэж үзэж байна.

2. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай заалтыг тусгана.

3. Хуулийг хэрэгжүүлснээр гарч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Энэхүү хуулийг баталснаар эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тодорхой ажиллагааг Чех Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх боломжтой болох бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломж бүрдэнэ.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах замаар гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар, мэдүүлэг авахын зэрэгцээ талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох боломжтой юм.

Түүнчлэн талуудын эрх бүхий байгууллагуудын алба хаагчид хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэх, ингэхдээ өөрсдийн биедээ авч ирсэн галт зэвсэг, сум, бусад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, албаны нохой, уналга морь зэргийг ашиглах боломжтой ба талуудын эрх бүхий байгууллагууд “Гамшгийн үеийн хохирогчийг тодорхойлох баг”-ийг нөгөө улсын нутаг дэвсгэрт харилцан томилох замаар тодорхой төрлийн ажиллагааг гүйцэтгэх боломж бий болно.

Дээр дурдсан хамтын ажиллагааны төрөл, хэлбэрээс гадна талууд сургалтын чиглэлээр хамтран ажиллах буюу хамтарсан сургалт, семинар, дадлага, сургуулилалт, хэлний сургалт зохион байгуулах, мэргэжилтнүүдийг сургах ба үүнд тодорхой ажилтныг томилон оролцуулах, сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулахад шинжээчдийг харилцан оролцуулах, дадлага, сургуулиалтад ажиглагчдыг оролцуулах боломж бүрдэх юм.

Уг хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар гарахгүй.

4. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг бусад хууль тогтоомжтой уялдуулсан байдал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэх бөгөөд хууль батлагдсантай холбогдуулан шинээр өөр хууль боловсруулах, бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй.

---oOo---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн тухай

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хирээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аялалын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан монголчууд ихээр зорчиж, амьдарч, мөн ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ хэлэлцээр байгуулах асуудалд тус яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр” нь 5 хэсэг, 29 зүйл, хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд уг хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой юм.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжиж, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгосноор уг хэлэлцээрт Талууд 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон заавал соёрхон батлах олон улсын гэрээ бөгөөд мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу уг хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулах юм.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн тухай

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хирээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аялалын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан монголчууд ихээр зорчиж, амьдарч, мөн ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ хэлэлцээр байгуулах асуудалд тус яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр” нь 5 хэсэг, 29 зүйл, хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд 1 дүгээр хэсэгт хэлэлцээрийн гол зорилго, талуудын хамтран тэмцэх, урьдчилан сэргийлэх зохион байгуулалттай гэмт хэргийн төрөл, хэлбэрийг тусгайлан авч үзсэн бол 2 дугаар хэсэгт хамтын ажиллагааны чиглэл, тэр дундаа талуудын эрх бүхий байгууллагууд гэмт хэрэг үйлдсэн зохион байгуулагч, тэдгээрийн холбоо хамаарал, бүтэц, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан арга техник, мөн террорист бүлэглэл, тэдгээрийн үйлдсэн гэмт хэрэг, цогцост шүүх шинжилгээний байгууллагаас хийсэн үзлэг, шинжилгээний дүгнэлт, криминологийн судалгаа, мөрдөн шалгах ажиллагааны арга тактик, түүнчлэн талуудын нутаг дэвсгэрт хилээр нэвтрэхдээ ашигласан бичиг баримт, оршин байгаа газар гэх зэрэг мэдээлэл, цагдаагийн байгууллагын бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг харилцан солилцохоос гадна талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгч ажиллах чиг үүрэг бүхий офицер, зөвлөх гэх мэргэжилтнүүдийг харилцан илгээхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Мөн талууд сургалтын чиглэлээр хамтран ажиллах буюу хамтарсан сургалт, семинар, дадлага, сургуулилалт, хэлний сургалт зохион байгуулах, мэргэжилтнүүдийг сургах ба үүнд тодорхой ажилтныг томилон оролцуулах, сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулахад шинжээчдийг харилцан оролцуулах, дадлага, сургуулиалтад ажиглагчдыг оролцуулах зэрэг асуудлыг тусгасан.

Хэлэлцээрийн 3 дугаар хэсэгт хамтын ажиллагааны тусгай хэлбэрүүд буюу тусгай хамгаалалт шаардагдах аливаа этгээдийг хамгаалах, тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх, уг этгээдэд холбогдох бүхий л төрлийн мэдээллийг харилцан солилцох, түүнчлэн талууд “Гамшгийн үеийн хохирогчийг тодорхойлох баг”-ийг томилох замаар тодорхой төрлийн ажиллагааг гүйцэтгүүлэхээр хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт илгээх асуудлыг тусгасан.

Хэлэлцээрийн 4 дүгээр хэсэгт талууд хувийн мэдээллийг авахаар нөгөө талдаа хүсэлт гаргах, хүсэлтийн дагуу мэдээллийг шилжүүлэх, мэдээллийг хүлээн авсан талын мэдээллийг бүртгэх, ашиглах, хамгаалах устгах арга хэлбэрийг тодорхойлсон.

Хэлэлцээрийн 5 дугаар хэсэгт хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд ашиглах хэл, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хэрэглэхтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх арга зам, хэлэлцээрийг дуусгавар болгохтой холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд хавсралт хэсэгт талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу тогтоосон нууцын ангилал, зэрэглэлийг дүйцүүлэн заасан ба талууд харилцан мэдээлэл солилцохдоо энэхүү хавсралтад заасан нууцын зэрэглэлийг илэрхийлсэн тэмдэглэгээг хэрэглэх тухай асуудлыг тусгасан.

Уг хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой юм.

Мөн энэхүү хэлэлцээрээр дамжуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах замаар гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар, мэдүүлэг авахаас гадна талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох боломжтой.

Түүнчлэн хэлэлцээрийн дагуу талуудын эрх бүхий байгууллагуудын алба хаагчид хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэх, ингэхдээ өөрсдийн биедээ авч ирсэн галт зэвсэг, сум, бусад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, албаны нохой, уналга морь зэргийг ашиглах боломжтой ба талуудын эрх бүхий байгууллагууд “Гамшгийн үеийн хохирогчийг тодорхойлох баг”-ийг нөгөө улсын нутаг дэвсгэрт харилцан томилох замаар тодорхой төрлийн ажиллагааг гүйцэтгэхтэй холбогдох харилцааг мөн зохицуулсан.


Бүгд Найрамдах Чех Улсын эрх бүхий байгууллагаас 2020-2025 онд эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх хүсэлтийн хүрээнд нийт 8 эрх зүйн туслалцааны хүсэлт (2020 онд 1, 2021 онд 1, 2022 онд 2, 2023 онд 2, 2024 онд 1, 2025 онд 1)-ийг тус яаманд ирүүлснийг холбогдох байгууллагад уламжилж, хүсэлтийн гүйцэтгэлийн хариуг тус улсын Хууль зүйн яаманд хүргүүлж байсан.

Одоогийн байдлаар Бүгд Найрамдах Чех Улсад танхайрах, бусдад хүч хэрэглэх, хулгайлах хэргээр манай улсын 4 иргэн хорих ял эдэлж байгаа бол 2024 онд оршин суух зөвшөөрөлгүйн улмаас 51 иргэн саатуулагдан шалгагдсан бөгөөд 2 иргэн гэмт хэргийн хохирогч болсон статистик мэдээлэл байна.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжиж, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгосноор уг хэлэлцээрт Талууд 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо гарын үсэг зурсан.

Энэхүү хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон заавал соёрхон батлах олон улсын гэрээ бөгөөд мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасны дагуу уг хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулах юм.

---oOo---



ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс нь (цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэх),

Гэмт хэрэгтэй тэмцэх эрх бүхий байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхийг эрмэлзэн,

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризмтой үр нөлөөтэй тэмцэхийг зорьж,

Хэлэлцэн тохирогч Талуудын нэгдэн орсон 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц болон түүний Протоколуудыг харгалзан үзэж,

Гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа нэн чухал ач холбогдолтой болохыг ухамсарлан хамтын ажиллагааг хялбаршуулж, оновчтой болгохыг эрэлхийлж,

Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалж, тэдгээрийг ардчилсан нийгэмд болохуйц, зайлшгүй шаардлагатай нөхцөл байдалд л хязгаарлаж болохыг ухамсарлаж,

Олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөж,

Дор дурдсан зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

I ХЭСЭГ

Хэлэлцээрийн зорилго

1 дүгээр зүйл

(1) Энэхүү Хэлэлцээрийн зорилго нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад, ялангуяа холбогдох эрх бүхий байгууллагууд бүх түвшинд өөр хоорондоо стратегийн болон ажиллагааны талаарх мэдээллийг харилцан солилцох, шууд харилцаа явуулах замаар хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэхэд оршино.

(2) Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрт хамаарах бусад чиглэлээр мөн хамтран ажиллана.

(3) Энэхүү Хэлэлцээрийн хүрээний хамтын ажиллагаанд шүүх эрх мэдлийн байгууллагын бүрэн эрхэд хамаарах эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудал хамаарахгүй.

2 дугаар зүйл

(1) Энэхүү Хэлэлцээрийн хамтын ажиллагааны хүрээнд гэмт үйлдлийн бүх хэлбэр хамаарах ба зохион байгуулалттай гэмт хэрэгт онцгойлон анхаарна.. Хэлэлцэн тохирогч Талууд, ялангуяа дараах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

- (a) Бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, алдар хүндийн эсрэг;
- (b) Терроризм, түүнийг санхүүжүүлэх;
- (c) Хүн худалдаалах, биеэ үнэлүүлэх, зуучлах, түүнчлэн хүний эд, эрхтэнийг худалдаалах;
- (d) Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл болон хүүхэд ашигласан порнограф;
- (e) Хэт даврах, арьс үндсээр алагчилах болон хэт үндсэрхэг үзэл гаргах;
- (f) 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц"-д заасан мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, тэр дундаа тэдгээрийн угтвар бодисын хууль бус эргэлт;
- (g) Галт зэвсэг, зэвсгийн шинж чанартай зүйл, сум, тэсрэх бодис, тэсрэх төхөөрөмж, химийн, биологийн, цацраг идэвхт бодис болон цемийн

материалыг, мөн стратегийн ач холбогдол бүхий бараа, технологи болон цэргийн эд зүйл, хэрэгсэл, түүнчлэн онц аюултай бусад төрлийн бодис болон аюултай хог хаягдлыг хууль бусаар үйлдвэрлэх, зуучлах, эзэмших, импортлох, экспортлох, дамжин тээвэрлэх болон худалдаалах;

(h) Мөнгө угаах гэмт хэрэг;

(i) Цахим гэмт хэрэг;

(j) Өмчийн эсрэг гэмт хэрэг, тухайлбал залилах, хулгайлах, тээврийн хэрэгслийг бусад хууль бус хэлбэрээр ашиглах;

(k) Мөнгөн тэмдэгт, тэмдэг, үнэт цаас, бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болон албан баримт бичиг, ялангуяа гадаад паспорт хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нийлүүлэх, ашиглах;

(l) Оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг;

(m) Эдийн засгийн бусад ноцтой гэмт хэрэг;

(n) Соёлын болон түүхийн үнэт зүйлийн эсрэг гэмт хэрэг;

(o) Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, ялангуяа ховор, нэн ховор ургамал, амьтан, түүний төрөл зүйлийг хууль бусаар худалдах.

II ХЭСЭГ

Хамтын ажиллагааны хэлбэрүүд

3 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтран ажиллах эрх бүхий байгууллагуудын талаар харилцан бие биедээ дипломат шугамаар мэдэгдэнэ. Ингэхдээ эрх бүхий байгууллагуудын холбоо барих хаяг, утас, факсын дугаар, эсхүл өөр бусад харилцах мэдээллийг мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтран ажиллах эрх бүхий байгууллагуудын мэдээллийн өөрчлөлтийг бие биедээ харилцан цаг алдалгүй мэдээлнэ.

(2) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт заасны дагуу мэдэгдсэн өгөгдлийн өөрчлөлтийн талаар харилцан бие биедээ даруй мэдэгдэнэ.

4 дүгээр зүйл

(1) Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтын ажиллагааг хүсэлтийг үндэслэн хэрэгжүүлнэ. Энэхүү Хэлэлцээрт заасны дагуу мэдээлэл авах, хийх арга хэлбэр, маягт, хэрэгжүүлэх арга хэмжээ, эсхүл хамтын ажиллагааны бусад хэлбэрийн талаарх хүсэлтийг бичгээр үйлдэж хүргүүлнэ. Факс, цахим шуудан болон цахим харилцааны бусад хэрэгслээр дамжуулан гаргасан хүсэлтийг бичгээр үйлдэж хүргүүлсэн хүсэлтэд тооцно. Хэрэв хувийн мэдээллийг шилжүүлэх бол баталгаат мэдээлэл дамжуулах аргыг заавал сонгоно. Яаралтай тохиолдолд хүсэлтийг амаар гаргаж болох ба даруй бичгээр баталгаажуулж хүргүүлнэ.

(2) Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага 1 дэх хэсэгт заасны дагуу хүсэлтийг үндэслэлгүй хойшлуулахгүйгээр биелүүлнэ. Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага нь хүсэлтийг биелүүлэхэд урт хугацаа шаардагдахаар бол хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагад хойшлуулшгүйгээр мэдээлж, хүсэлтийг биелүүлэх эцсийн хугацааг мэдэгдэнэ.

(3) Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага нь хүсэлтийг биелүүлэхэд нэмэлт мэдээлэл шаардлагатай бол түүнийг хүсэж болно.

(4) Хэрэв хүсэлт нь хүлээн авагч байгууллагын бүрэн эрхэд хамаарахгүй бол уг хүсэлтийг эрх бүхий байгууллагад хойшлуулшгүйгээр хүргүүлэх бөгөөд энэ тухай хүсэлт гаргасан байгууллагад мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд тодорхой хэргүүд дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад шаардлагатай гэж үзсэн мэдээллийг хүсэлтгүйгээр харилцан хүргүүлж болно.

6 дугаар зүйл

(1) Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал хүсэлтийг биелүүлэх нь тухайн улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал болон бусад амин чухал ашиг сонирхолд аюул учруулж болзошгүй, эсхүл олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, эсхүл үндэсний хууль тогтоомжтой зөрчилдсөн гэж үзвэл хамтын ажиллагааны хүсэлтээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзаж болно.

(2) Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлтийг биелүүлэхээс татгалзсан эсхүл хэсэгчлэн биелүүлэх тохиолдолд энэ тухай даруй бие биедээ бичгээр мэдээлнэ.

(3) Хүсэлтийг биелүүлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талууд нөхцөл тавьж болно.

7 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь хувийн мэдээлэл, ажиллагааны мэдээлэл, мөн цагдаагийн болон бусад албан ёсны мэдээллийн сан, бүртгэлийн мэдээллийг хүргүүлэх замаар бие биедээ дэмжлэг үзүүлнэ. Тухайлбал энэхүү мэдээлэл нь дараах агуулгатай байж болно:

(a) Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, гэмт хэрэгт сэжиглэгдсэн эсхүл гэмт хэрэгт холбогдсон хүмүүс, гэмт этгээдүүдийн хоорондын холбоо, гэмт хэрэгт холбогдсон бүлэглэлүүдийн зохион байгуулалт болон тэдгээрийн бүтэц, гэмт этгээдүүд болон гэмт бүлэглэлүүдийн ердийн зан байдал, эрүүгийн хууль тогтоомж зөрчсөн болон тэдгээрт оногдуулсан арга хэмжээ;

(b) Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт үйлдэхээр төлөвлөсөн террорист үйлдэл болон гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж буй, үйлдэж буй эсхүл гэмт хэрэг үйлдсэн террорист бүлэглэлүүд;

(c) Гэмт хэрэг үйлдэх үед зэвсгийн чанартай ашигласан болон гэмт хэргийн эд зүйлс; Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь эдгээр эд зүйлсийн дээжийг бие биедээ хүргүүлнэ;

(d) Шүүх эмнэлгийн туршлага, мэдээлэл, шүүх эмнэлгийн болон криминологийн судалгааны үр дүн, мөрдөн шалгах ажиллагааны туршлага, арга барил болон арга хэлбэр;

(e) Хэлэлцэн тохирогч Талуудын хилийг дамнаж үйлдэгдсэн гэмт хэргийн шинэ төрөл, арга барил.

(2) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт нэвтрэх, оршин суухтай холбоотой ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, тухайлбал тухайн хүний хувийн байдал, улсын хилээр нэвтэрсэн газар орон, огноо, Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрөл, оршин суух газар, мөн аялалын болон албан бичиг баримтын үнэн зөв, хүчинтэй эсэх талаарх мэдээллийг бие биедээ хүргүүлнэ.

(3) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь хууль тогтоомж, судалгааны болон үзэл баримтлалын талаарх материал, тусгай мэдлэгийн болон техникийн мэдээлэл, тусгай ном зохиолыг харилцан солилцоно.

8 дугаар зүйл

Шаардлагатай тохиолдолд, Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь үйл ажиллагаагаа уялдуулж, дараах чиглэлээр бие биедээ дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

(a) Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй, түүнчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял эдлэхээс оргон зайлсан хүмүүсийг эрэн сурвалжлах;

(b) Сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлах, тэр дундаа нэр, хаяг нь тодорхойгүй хүн, эсхүл цогцсыг таниулахтай холбоотой ажиллагаа;

(c) Терроризмыг санхүүжүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг тогтоох, илрүүлэх, хураан авах;

(d) Тайлбар, мэдүүлэг авах;

(e) Хэлэлцэн тохирогч Талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу хамгаалалтын арга хэрэгслийг бий болгох, харилцан солилцох, тэр дундаа Хэлэлцэн тохирогч Талуудын мэдээллийн системд зохих арга хэмжээг авах; Хамгаалалтын арга хэрэгслийг хүргүүлсэн Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллага нь тэдгээрийг ашиглах, хадгалах, буцаах, түүнчлэн үрэгдүүлсэн, устгасан тохиолдолд дагаж мөрдөх журмыг тогтоож болно;

(f) Шинжээч болон шүүх эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлээр, тухайлбал ул мөрийг тогтоох, бэхжүүлэх, үнэлэх, харьцуулах;

(g) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын танилцах эрхтэй цахим ул мөр, нууцлалтай мэдээллийг олж авах, үнэлэх, цахим харилцаа холбооны холбогдох мэдээллийг солилцох, түүнчлэн цахим гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, тэр дундаа цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох;

(h) Сэжигтэй эд зүйлийг шинжлэх, тэсрэх төхөөрөмжийг идэвхгүй болгох, сум, тэсэрч дэлбэрэх бодис, тэсрэх аюултай эд зүйл олдсон үед устгах;

(i) Хяналттай хүргэх, ажиглах, халхавчлагдсан ажиллагаа зэрэг мөрдөн шалгах тусгайлсан арга тактикт бэлтгэх, хэрэгжүүлэх;

(j) Хэлэлцэн тохирогч нөгөө Талуудын хүсэлтийн дагуу бусад холбогдох арга хэмжээг авах, тухайлбал гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгслийг шалгах;

(k) Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт нэвтрэх, оршин суухтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгын хүрээнд;

(l) Тусгайлсан арга хэмжээнд бэлтгэх зорилгоор ажлын уулзалтыг зохион байгуулах;

(m) Албаны нохой, уналганы морь болон тоног төхөөрөмж түр хугацаагаар ашиглуулах:

(n) Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх.

9 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт холбогч офицеруудыг илгээж болно.

(2) Холбогч офицерууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дэмжлэг үзүүлэх, зөвлөх байдлаар идэвхтэй ажиллана. Эдгээр холбогч офицерууд нь Хэлэлцэн тохирогч илгээгч Талаас өгсөн зааврын хүрээнд мэдээлэл хүргүүлж, үүрэг даалгавраа гүйцэтгэнэ. Эдгээр холбогч офицерууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт аливаа эрх мэдлийг хэрэгжүүлэхгүй.

(3) Хэлэлцэн тохирогч нэг Талын холбогч офицерыг гуравдагч улс руу илгээхэд Хэлэлцэн тохирогч Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр болон гуравдагч улс бичгээр зөвшөөрөл өгсөн тохиолдолд холбогч офицер нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын ашиг сонирхлыг мөн төлөөлж болно.

10 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талыг дэмжих, үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор зөвлөхүүдийг илгээж, мөн судалгааны холимог болон бусад ажлын хэсгийг байгуулж болно.

(2) 1 дүгээр хэсэгт заасан алба хаагчид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дэмжих, зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Эдгээр алба хаагчид нь дэмжих, зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тэдгээрийг илгээсэн Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагуудын зааврыг дагана. Эдгээр алба хаагчид нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт аливаа эрх мэдлийг хэрэгжүүлэхгүй.

11 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд сургалтын болон боловсролын хүрээнд тухайлбал дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

(a) Хэлэлцэн тохирогч нэг Талын алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас зохион байгуулах сургалтад хамруулах;

(b) Хамтарсан семинар, сургуулилт, хэлний сургалт зохион байгуулах;

(c) Мэргэжилтнүүдийг бэлтгэх;

(d) Шинжээчид, түүнчлэн сургалтын агуулга, хөтөлбөрийг харилцан солилцох;

(e) Сургуулилтад ажиглагчдыг оролцуулах.

III ХЭСЭГ

Хамтын ажиллагааны тусгай хэлбэрүүд

12 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохирогч нэг Талын алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байршуулж, түүний удирдлага дор эрх бүхий байгууллагад үүрэг даалгавраа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж болно.

(2) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа явуулж буй алба хаагчид тус Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж болно. Алба хаагчид бүрэн эрхээ зөвхөн зааврын дагуу, мөн журмын дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын алба хаагчийг байлцуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ. Эдгээр алба хаагчдын үйлдлүүд тэдгээрийг хариуцаж буй Хэлэлцэн тохирогч Талын алба хаагчид хамаарна.

13 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шаардлагатай тохиолдолд хүмүүсийг эсхүл барилга байгууламжуудыг хамгаалуулах зорилгоор Хэлэлцэн тохирогч нэг Талын алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт илгээж болно.

(2) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа явуулж буй алба хаагчид зөвхөн 1 дэх хэсэгт заасан үүрэг даалгаврыг биелүүлэхтэй холбогдох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна Хэлэлцэн тохирогч нөгөө Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу өөрийгөө хамгаалах арга хэмжээ авч болно. Эдгээр алба хаагчид нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүрэг даалгаврыг гүйцэтгэхдээ олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Эдгээр алба хаагчид нь

Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гарсан бүх ослын талаар 1 дэх хэсэгт заасан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад хойшлуулшгүйгээр тайлагнана.

14 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны улмаас бие махбодод нь гэмтэл учрах эсхүл бусад ноцтой аюул учрах магадлалтай гэрч болон бусад хүмүүсийг хамгаалахтай холбоотой арга хэмжээг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхэд хамтран ажиллана (цаашид "хамгаалагдсан хүн" гэх).

(2) Хамтын ажиллагаанд, тухайлбал хувийн мэдээлэл солилцох, логистикийн дэмжлэг үзүүлэх, түүнчлэн хамгаалагдсан хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой харилцаа хамаарна.

(3) Нүүлгэн шилжүүлэх гэж буй хамгаалагдсан хүнийг хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Талын гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрт хамруулна. Хамгаалагдсан хүнийг хамгаалах арга хэмжээг хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу зохицуулна. Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Тал нь хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талыг дээрх арга хэмжээг авахад шаардлагатай бүх мэдээллээр хангана.

(4) Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Тал нь шаардлагатай бол хамгаалагдсан хүний амьжиргааны зардлыг, түүнчлэн тусгайлсан арга хэмжээг биелүүлэхэд шаардлагатай зардлыг хариуцна. Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Тал нь хамгаалагдсан хүнийг хамгаалахтай холбоотой хувийн болон материаллаг зардлыг хариуцна. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь хамгаалагдсан хүнийг нүүлгэн шилжүүлэхээс өмнө нарийвчилсан мэдээллийн талаар тохиролцоно.

(5) Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Тал нь ноцтой шалтгааны улмаас болон хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Талд урьдчилан мэдэгдсэний дараа 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг дуусгавар болгож болно. Энэ тохиолдолд хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Тал хамгаалагдсан хүнийг буцаан авах үүрэгтэй.

15 дугаар зүйл

Албан тушаал, чиг үүрэгтэй нь холбогдуулан аюулгүй байдлыг нь хангах үүднээс Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагуудын хамгаалалтад буй тухайн хүн (цаашид "тусгай хамгаалалт бүхий хүн")-ийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх, эсхүл уг нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх үед Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд энэхүү нөхцөл байдлын талаар бичгээр, тухайлбал, факсаар, цахим шуудангаар, эсхүл харилцаа холбооны бусад цахим хэлбэрээр дамжуулан Хэлэлцэн тохирогч нэг Талын улсын

хилээр нэвтрэхээс 24 цагаас багагүй хугацааны өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдээлнэ. Энэхүү мэдээлэлд тусгай хамгаалалт бүхий хүний хувийн, нэг газраас нөгөө газарт зорчиж буй тээврийн хэрэгсэл, түүний төрөл, Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэрт байх хугацаа, байрлах газар орон, Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэрт ирэх болон буцах тов. улсын хилээр нэвтрэх болон гарах газар орон, түүнийг дагалдан яваа алба хаагчид, тэдгээрийн утасны дугаарын жагсаалт, мөн тэдгээр алба хаагчдын биедээ авч яваа галт зэвсгийн жагсаалт, тэдгээрийн дугаар болон доторх сум, богино долгионы тусгай хэрэгсэл ашиглах зөвшөөрөл олгохыг хүссэн тухай хүсэлт, тусгай хамгаалалт бүхий хүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байрлуулах газар оронд Хэлэлцэн тохирогч тухайн Талын эрх бүхий байгууллагуудаас хамгаалалт хүссэн тухай хүсэлтийн талаар тусгана.

16 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талууд гамшгийн үеийн хохирогчдыг тогтооход хамтран ажиллана. Энэхүү хамтын ажиллагаанд тухайлбал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр байгаа хохирогчийг тогтооход ашигласан мэдээллийг дараа нь баталгаажуулахаар биечлэн олж авах боломж, хохирогчийг тогтооход ашигласан мэдээллийг солилцох, түүнчлэн гамшгийн үеийн хохирогчийг тогтоох тусгай баг (цаашид "ГҮХТ баг" гэх)-ийг илгээх асуудал багтана.

(2) Шаардлагатай үед Хэлэлцэн тохирогч аль нэг Тал "ГҮХТ баг"-ийг хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт илгээх хүсэлтийг нөгөө Талдаа гаргаж болно. "ГҮХТ баг"-ийн алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хэсэгчилсэн даалгавар гүйцэтгүүлэхээр илгээхдээ өөрийн улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авна.

(3) Хэрэв "ГҮХТ баг", эсхүл түүний алба хаагчид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр ажиллагаа гүйцэтгэх бол "ГҮХТ баг"-ийн алба хаагчид нь Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэр дээрх алба хаагчдаас хамтран ажиллахыг хүсэх эрхтэй.

(4) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын "ГҮХТ баг"-ийг ажиллуулах хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Тал нь журамд заасны дагуу өөрийн алба хаагчийг уг багт орж ажиллах явдлыг хангана.

(5) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр ажиллагаа гүйцэтгэж буй "ГҮХТ баг"-ийн алба хаагчид өөрийн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу таних тэмдэг заавал зүүнэ.

(6) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын алба хаагч бус боловч "ГҮХТ баг"-ийн энгийн гишүүд болох шинжээчдийг энэ зүйлд заасан хамтын ажиллагааны зорилгоор Хэлэлцэн тохирогч Талын алба хаагчид мөн тооцно. Энэхүү хэлэлцээрийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн сүүлийн өгүүлбэр, мөн 20.3 болон 20.5 дахь хэсгүүд эдгээр алба хаагчдад хамаарахгүй.

IV ДЭХ ХЭСЭГ

Эрх зүйн харилцаа

17 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн дагуу хувийн мэдээллийг шилжүүлэх бол тухайн мэдээллийг ашиглахад дараах заалтууд хамаарна. Үүнд:

(а) Хувийн мэдээлэл хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь тухайн хувийн мэдээллийг зөвхөн шилжүүлэн авсан зорилгынхоо хүрээнд болон шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талын тавьсан нөхцөлийн дагуу ашиглаж болно. Түүнчлэн тухайн хувийн мэдээллийг энэхүү Хэлэлцээрийн хүрээнд зөвшөөрөх бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөн олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талаас тавьсан нөхцөлийн дагуу ашиглана. Хувийн мэдээллийг шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч талын зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр тухайн хувийн мэдээллийг өөр бусад зорилгоор ашиглаж болно.

(b) Шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Талд хүсэлт гаргавал хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь тухайн хувийн мэдээллийг хэрхэн ашигласан болон түүнээс гарсан үр дүнг мэдээлнэ.

(c) Шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Тал нь тухайн хувийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, мөн шилжүүлэх нь хүссэн зорилгод нийцсэн, шаардлагатай эсэхийг шалгах үүрэгтэй. Шилжүүлэн өгсөн хувийн мэдээлэл нь шилжүүлэн өгсний дараа алдаатай, эсхүл шилжүүлэн өгөх шаардлагагүй болох нь тогтоогдсон тохиолдолд энэ талаар хувийн мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд даруй заавал мэдэгдэнэ. Хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал алдаатай хувийн мэдээллийн алдааг засварлах, эсхүл шилжүүлэн авах шаардлагагүй байсан хувийн мэдээллийг устгана.

(d) Хүсэлт гаргавал тухайн хувийн мэдээлэлд холбогдох этгээдэд энэхүү Хэлэлцээрийн дагуу шилжүүлэн өгсөн, эсхүл боловсруулсан хувийн мэдээллийн талаар, мөн тухайн мэдээллийг ашиглах зорилгын талаарх мэдээллийг заавал гаргаж өгнө. Дээр дурдсан зүйл нь үндэсний хууль тогтоомжийн дагуу олон нийтийн ашиг сонирхлын үүднээс тухайн мэдээллийг шилжүүлэн өгөхгүй байх нь уг мэдээллийг олж авах тухайн хувь хүний ашиг сонирхлыг хөндөхгүй байх тохиолдолд хамаарна.

(e) Энэ зүйлийн "d" хэсэгт дурдсан асуудлаар гаргасан хүсэлтийг шийдвэрлэхээс өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагын саналыг байнга авна. Хувийн мэдээлэлд холбогдох этгээдийн хүсэлтийг шийдвэрлэх Хэлэлцэн тохирогч Тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр тухайн этгээдэд мэдээлэхгүй. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн мэдээллийг хувь этгээдэд өгөхгүй байхыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас хүсэж болно. Бусад

тохиолдолд өөрийн хувийн мэдээллийг олж авах хувь хүний эрхийг тухайн хувь хүний гаргасан хүсэлтийг шийдвэрлэх Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

(f) Мэдээлэлд хамаарах этгээд нь шилжүүлэн өгсөн өөрийн хувийн мэдээлэлд засвар оруулах, мөн нэмэлт мэдэгдэл гаргах хэлбэрээр дутуу мэдээллийг бүрэн болгох тухай хүсэлт гаргах эрхтэй. Дээр дурдсан зүйл нь үндэсний хууль тогтоомжийн дагуу олон нийтийн ашиг сонирхлын үүднээс уг мэдээлэлд засвар оруулахаас татгалзах, эсхүл татгалзсан шалтгааныг тайлбарлахгүй байх нь тухайн хувь хүний ашиг сонирхлыг хөндөхгүй тохиолдолд хамаарна. Энэ зүйлийн "e" хэсэг энэ тохиолдолд нэгэн адил хэрэглэгдэнэ.

(g) Хэрэв шилжүүлэн өгсөн мэдээллийг тухайн мэдээлэлд хамаарах этгээдийн эрх болон хамгаалагдсан ашиг сонирхлын эсрэг буюу хувийн мэдээллийг зөвхөн автоматаар боловсруулахад ашигласан бол тухайн хувь этгээд хувийн мэдээллийг боловсруулах зорилго, хэлбэрийг тодорхойлох асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас өөрийн оролцоог хангуулах эрхтэй.

(h) Шилжүүлэн өгсөн хувийн мэдээлэлд зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүний арьсны өнгө, үндэс, угсаа, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, эсхүл философийн итгэл үнэмшил, эсхүл үйлдвэрчний эвлэлийн байгууллагад гишүүнчлэлтэй эсэх талаар болон генетикийн болон биеийн давхцахгүй өгөгдөл болох биометрийн, эрүүл мэнд, бэлгийн амьдрал буюу бэлгийн чиг хандлагын талаарх мэдээллийг тусгахыг зөвшөөрнө.

(g) Галт зэвсэг, зэвсгийн шинж чанартай зүйл, сум, тэсрэх бодис, тэсрэх төхөөрөмж, химийн, биологийн, цацраг идэвхт бодис болон цөмийн материалыг, мөн стратегийн ач холбогдол бүхий бараа, технологи болон цэргийн эд зүйл, хэрэгсэл, түүнчлэн онц аюултай бусад төрлийн бодис болон аюултай хог хаягдлыг хууль бусаар үйлдвэрлэх, зуучлах, эзэмших, импортлох, экспортлох, дамжин тээвэрлэх болон худалдаалах;

(h) Мөнгө угаах гэмт хэрэг;

(i) Цахим гэмт хэрэг;



(j) Өмчийн эсрэг гэмт хэрэг, тухайлбал залилах, хулгайлах, тээврийн хэрэгслийг бусад хууль бус хэлбэрээр ашиглах;

(k) Мөнгөн тэмдэгт, тэмдэг, үнэт цаас, бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болон албан баримт бичиг, ялангуяа гадаад паспорт хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нийлүүлэх, ашиглах;

(l) Оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг;

(m) Эдийн засгийн бусад ноцтой гэмт хэрэг;

(n) Соёлын болон түүхийн үнэт зүйлийн эсрэг гэмт хэрэг;

(o) Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, ялангуяа ховор, нэн ховор ургамал, амьтан, түүний төрөл зүйлийг хууль бусаар худалдах.

II ХЭСЭГ

Хамтын ажиллагааны хэлбэрүүд

3 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтран ажиллах эрх бүхий байгууллагуудын талаар харилцан бие биедээ дипломат шугамаар мэдэгдэнэ. Ингэхдээ эрх бүхий байгууллагуудын холбоо барих хаяг, утас, факсын дугаар, эсхүл өөр бусад харилцах мэдээллийг мэдэгдэнэ. Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтран ажиллах эрх бүхий байгууллагуудын мэдээллийн өөрчлөлтийг бие биедээ харилцан цаг алдалгүй мэдээлнэ.

(2) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд 1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрт заасны дагуу мэдэгдсэн өгөгдлийн өөрчлөлтийн талаар харилцан бие биедээ даруй мэдэгдэнэ.

4 дүгээр зүйл

(1) Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтын ажиллагааг хүсэлтийг үндэслэн хэрэгжүүлнэ. Энэхүү Хэлэлцээрт заасны дагуу мэдээлэл авах, хийх арга хэлбэр, маягт, хэрэгжүүлэх арга хэмжээ, эсхүл хамтын ажиллагааны бусад хэлбэрийн талаарх хүсэлтийг бичгээр үйлдэж хүргүүлнэ. Факс, цахим шуудан болон цахим харилцааны бусад хэрэгслээр дамжуулан гаргасан хүсэлтийг бичгээр үйлдэж хүргүүлсэн хүсэлтэд тооцно. Хэрэв хувийн мэдээллийг шилжүүлэх бол баталгаат



мэдээлэл дамжуулах аргыг заавал сонгоно. Яаралтай тохиолдолд хүсэлтийг амаар гаргаж болох ба даруй бичгээр баталгаажуулж хүргүүлнэ.

(2) Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага 1 дэх хэсэгт заасны дагуу хүсэлтийг үндэслэлгүй хойшлуулахгүйгээр биелүүлнэ. Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага нь хүсэлтийг биелүүлэхэд урт хугацаа шаардагдахаар бол хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагад хойшлуулшгүйгээр мэдээлж, хүсэлтийг биелүүлэх эцсийн хугацааг мэдэгдэнэ.

(3) Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага нь хүсэлтийг биелүүлэхэд нэмэлт мэдээлэл шаардлагатай бол түүнийг хүсэж болно.

(4) Хэрэв хүсэлт нь хүлээн авагч байгууллагын бүрэн эрхэд хамаарахгүй бол уг хүсэлтийг эрх бүхий байгууллагад хойшлуулшгүйгээр хүргүүлэх бөгөөд энэ тухай хүсэлт гаргасан байгууллагад мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд тодорхой хэргүүд дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад шаардлагатай гэж үзсэн мэдээллийг хүсэлтгүйгээр харилцан хүргүүлж болно.

6 дугаар зүйл


(1) Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал хүсэлтийг биелүүлэх нь тухайн улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал болон бусад амин чухал ашиг сонирхолд аюул учруулж болзошгүй, эсхүл олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, эсхүл үндэсний хууль тогтоомжтой зөрчилдсөн гэж үзвэл хамтын ажиллагааны хүсэлтээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзаж болно.

(2) Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлтийг биелүүлэхээс татгалзсан эсхүл хэсэгчлэн биелүүлэх тохиолдолд энэ тухай даруй бие биедээ бичгээр мэдээлнэ.

(3) Хүсэлтийг биелүүлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талууд нөхцөл тавьж болно.

7 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь хувийн мэдээлэл, ажиллагааны мэдээлэл, мөн цагдаагийн болон бусад албан ёсны



мэдээллийн сан; бүртгэлийн мэдээллийг хүргүүлэх замаар бие биедээ дэмжлэг үзүүлнэ. Тухайлбал энэхүү мэдээлэл нь дараах агуулгатай байж болно:

(a) Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, гэмт хэрэгт сэжиглэгдсэн эсхүл гэмт хэрэгт холбогдсон хүмүүс, гэмт этгээдүүдийн хоорондын холбоо, гэмт хэрэгт холбогдсон бүлэглэлүүдийн зохион байгуулалт болон тэдгээрийн бүтэц, гэмт этгээдүүд болон гэмт бүлэглэлүүдийн ердийн зан байдал, эрүүгийн хууль тогтоомж зөрчсөн болон тэдгээрт оногдуулсан арга хэмжээ;

(b) Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт үйлдэхээр төлөвлөсөн террорист үйлдэл болон гэмт хэрэг үйлдэхээр төлөвлөж буй, үйлдэж буй эсхүл гэмт хэрэг үйлдсэн террорист бүлэглэлүүд;

(c) Гэмт хэрэг үйлдэх үед зэвсгийн чанартай ашигласан болон гэмт хэргийн эд зүйлс: Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь эдгээр эд зүйлсийн дээжийг бие биедээ хүргүүлнэ;

(d) Шүүх эмнэлгийн туршлага, мэдээлэл, шүүх эмнэлгийн болон криминологийн судалгааны үр дүн, мөрдөн шалгах ажиллагааны туршлага, арга барил болон арга хэлбэр;

(e) Хэлэлцэн тохирогч Талуудын хилийг дамнаж үйлдэгдсэн гэмт хэргийн шинэ төрөл, арга барил.


(2) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт нэвтрэх, оршин суухтай холбоотой ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, тухайлбал тухайн хүний хувийн байдал, улсын хилээр нэвтэрсэн газар орон, огноо, Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрөл, оршин суух газар, мөн аялалын болон албан бичиг баримтын үнэн зөв, хүчинтэй эсэх талаарх мэдээллийг бие биедээ хүргүүлнэ.

(3) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь хууль тогтоомж, судалгааны болон үзэл баримтлалын талаарх материал, тусгай мэдлэгийн болон техникийн мэдээлэл, тусгай ном зохиолыг харилцан солилцоно.

8 дугаар зүйл

Шаардлагатай тохиолдолд, Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь үйл ажиллагаагаа уялдуулж, дараах чиглэлээр бие биедээ дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

(a) Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй, түүнчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ял эдлэхээс оргон зайлсан хүмүүсийг эрэн сурвалжлах;



(b) Сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжлах, тэр дундаа нэр, хаяг нь тодорхойгүй хүн, эсхүл цогцсыг таниулахтай холбоотой ажиллагаа;

(c) Терроризмыг санхүүжүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг тогтоох, илрүүлэх, хураан авах;

(d) Тайлбар, мэдүүлэг авах;

(e) Хэлэлцэн тохирогч Талуудын үндэсний хууль тогтоомжийн дагуу хамгаалалтын арга хэрэгслийг бий болгох, харилцан солилцох, тэр дундаа Хэлэлцэн тохирогч Талуудын мэдээллийн системд зохих арга хэмжээг авах; Хамгаалалтын арга хэрэгслийг хүргүүлсэн Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага нь тэдгээрийг ашиглах, хадгалах, буцаах, түүнчлэн үрэгдүүлсэн, устгасан тохиолдолд дагаж мөрдөх журмыг тогтоож болно;

(f) Шинжээч болон шүүх эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлээр, тухайлбал ул мөрийг тогтоох, бэхжүүлэх, үнэлэх, харьцуулах;

(g) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын танилцах эрхтэй цахим ул мөр, нууцлалтай мэдээллийг олж авах, үнэлэх, цахим харилцаа холбооны холбогдох мэдээллийг солилцох, түүнчлэн цахим гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, тэр дундаа цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох;

(h) Сэжигтэй эд зүйлийг шинжлэх, тэсрэх төхөөрөмжийг идэвхгүй болгох, сум, тэсэрч дэлбэрэх бодис, тэсрэх аюултай эд зүйл олдсон үед устгах;

(i) Хяналттай хүргэх, ажиглах, халхавчлагдсан ажиллагаа зэрэг мөрдөн шалгах тусгайлсан арга тактикт бэлтгэх, хэрэгжүүлэх;


(j) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хүсэлтийн дагуу бусад холбогдох арга хэмжээг авах, тухайлбал гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зорилгоор тээврийн хэрэгслийг шалгах;

(k) Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт нэвтрэх, оршин суухтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгын хүрээнд;

(l) Тусгайлсан арга хэмжээнд бэлтгэх зорилгоор ажлын уулзалтыг зохион байгуулах;

(m) Албаны нохой, уналганы морь болон тоног төхөөрөмж түр хугацаагаар ашиглуулах;

(n) Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх.



9 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохирогч аль нэг Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талтай харилцан тохиролцсоны үндсэн дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт холбогч офицеруудыг илгээж болно.

(2) Холбогч офицерууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дэмжлэг үзүүлэх, зөвлөх байдлаар идэвхтэй ажиллана. Эдгээр холбогч офицерууд нь Хэлэлцэн тохирогч илгээгч Талаас өгсөн зааврын хүрээнд мэдээлэл хүргүүлж, үүрэг даалгавраа гүйцэтгэнэ. Эдгээр холбогч офицерууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт аливаа эрх мэдлийг хэрэгжүүлэхгүй.

(3) Хэлэлцэн тохирогч нэг Талын холбогч офицерыг гуравдагч улс руу илгээхэд Хэлэлцэн тохирогч Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр болон гуравдагч улс бичгээр зөвшөөрөл өгсөн тохиолдолд холбогч офицер нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын ашиг сонирхлыг мөн төлөөлж болно.

10 дугаар зүйл


(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талыг дэмжих, үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор зөвлөхүүдийг илгээж, мөн судалгааны холимог болон бусад ажлын хэсгийг байгуулж болно.

(2) 1 дүгээр хэсэгт заасан алба хаагчид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт дэмжих, зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Эдгээр алба хаагчид нь дэмжих, зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ тэдгээрийг илгээсэн Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагуудын зааврыг дагана. Эдгээр алба хаагчид нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт аливаа эрх мэдлийг хэрэгжүүлэхгүй.

11 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талууд сургалтын болон боловсролын хүрээнд, тухайлбал дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

- (a) Хэлэлцэн тохирогч нэг Талын алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас зохион байгуулах сургалтад хамруулах;
- (b) Хамтарсан семинар, сургуулилт, хэлний сургалт зохион байгуулах;
- (c) Мэргэжилтнүүдийг бэлтгэх;
- (d) Шинжээчид, түүнчлэн сургалтын агуулга, хөтөлбөрийг харилцан солилцох;
- (e) Сургуулилтад ажиглагчдыг оролцуулах.



III ХЭСЭГ

Хамтын ажиллагааны тусгай хэлбэрүүд

12 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шаардлагатай тохиолдолд Хэлэлцэн тохирогч нэг Талын алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байршуулж, түүний удирдлага дор эрх бүхий байгууллагад үүрэг даалгавраа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж болно.

(2) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа явуулж буй алба хаагчид тус Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж болно. Алба хаагчид бүрэн эрхээ зөвхөн зааврын дагуу, мөн журмын дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын алба хаагчийг байлцуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ. Эдгээр алба хаагчдын үйлдлүүд тэдгээрийг хариуцаж буй Хэлэлцэн тохирогч Талын алба хаагчид хамаарна.

13 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шаардлагатай тохиолдолд хүмүүсийг эсхүл барилга байгууламжуудыг хамгаалуулах зорилгоор Хэлэлцэн тохирогч нэг Талын алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт илгээж болно.

(2) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа явуулж буй алба хаагчид зөвхөн 1 дэх хэсэгт заасан үүрэг даалгаврыг биелүүлэхтэй холбогдох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна Хэлэлцэн тохирогч нөгөө Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу өөрийгөө хамгаалах арга хэмжээ авч болно. Эдгээр алба хаагчид нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүрэг даалгаврыг гүйцэтгэхдээ олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Эдгээр алба хаагчид нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гарсан бүх ослын талаар 1 дэх хэсэгт заасан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад хойшлуулшгүйгээр тайлагнана.

14 дүгээр зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагааны улмаас бие махбодод нь гэмтэл учрах эсхүл бусад ноцтой аюул учрах магадлалтай гэрч болон бусад хүмүүсийг хамгаалахтай холбоотой арга хэмжээг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхэд хамтран ажиллана (цаашид "хамгаалагдсан хүн" гэх).



(2) Хамтын ажиллагаанд, тухайлбал хувийн мэдээлэл солилцох, логистикийн дэмжлэг үзүүлэх, түүнчлэн хамгаалагдсан хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой харилцаа хамаарна.

(3) Нүүлгэн шилжүүлэх гэж буй хамгаалагдсан хүнийг хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Талын гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрт хамруулна. Хамгаалагдсан хүнийг хамгаалах арга хэмжээг хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу зохицуулна. Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Тал нь хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Талыг дээрх арга хэмжээг авахад шаардлагатай бүх мэдээллээр хангана.

(4) Хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Тал нь шаардлагатай бол хамгаалагдсан хүний амьжиргааны зардлыг, түүнчлэн тусгайлсан арга хэмжээг биелүүлэхэд шаардлагатай зардлыг хариуцна. Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Тал нь хамгаалагдсан хүнийг хамгаалахтай холбоотой хувийн болон материаллаг зардлыг хариуцна. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь хамгаалагдсан хүнийг нүүлгэн шилжүүлэхээс өмнө нарийвчилсан мэдээллийн талаар тохиролцоно.

(5) Хүсэлт хүлээн авагч Хэлэлцэн тохирогч Тал нь ноцтой шалтгааны улмаас болон хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Талд урьдчилан мэдэгдсэний дараа 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг дуусгавар болгож болно. Энэ тохиолдолд хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Тал хамгаалагдсан хүнийг буцаан авах үүрэгтэй.

15 дугаар зүйл

Албан тушаал, чиг үүрэгтэй нь холбогдуулан аюулгүй байдлыг нь хангах үүднээс Хэлэлцэн тохирогч нэг Талын эрх бүхий байгууллагуудын хамгаалалтад буй тухайн хүн (цаашид "тусгай хамгаалалт бүхий хүн")-ийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх, эсхүл уг нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх үед Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд энэхүү нөхцөл байдлын талаар бичгээр, тухайлбал, факсаар, цахим шуудангаар, эсхүл харилцаа холбооны бусад цахим хэлбэрээр дамжуулан Хэлэлцэн тохирогч нэг Талын улсын хилээр нэвтрэхээс 24 цагаас багагүй хугацааны өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талд мэдээлнэ. Энэхүү мэдээлэлд тусгай хамгаалалт бүхий хүний хувийн, нэг газраас нөгөө газарт зорчиж буй тээврийн хэрэгсэл, түүний төрөл, Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэрт байх хугацаа, байрлах газар орон, Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэрт ирэх болон буцах тов, улсын хилээр нэвтрэх болон гарах газар орон, түүнийг дагалдан яваа алба хаагчид, тэдгээрийн утасны дугаарын жагсаалт, мөн тэдгээр алба хаагчдын биедээ авч яваа галт зэвсгийн жагсаалт, тэдгээрийн дугаар болон доторх сум, богино долгионы тусгай хэрэгсэл ашиглах зөвшөөрөл олгохыг хүссэн тухай хүсэлт, тусгай хамгаалалт бүхий хүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байрлуулах газар оронд Хэлэлцэн тохирогч тухайн Талын эрх бүхий байгууллагуудаас хамгаалалт хүссэн тухай хүсэлтийн талаар тусгана.



16 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч Талууд гамшгийн үеийн хохирогчдыг тогтооход хамтран ажиллана. Энэхүү хамтын ажиллагаанд тухайлбал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр байгаа хохирогчийг тогтооход ашигласан мэдээллийг дараа нь баталгаажуулахаар биечлэн олж авах боломж, хохирогчийг тогтооход ашигласан мэдээллийг солилцох, түүнчлэн гамшгийн үеийн хохирогчийг тогтоох тусгай баг (цаашид "ГҮХТ баг" гэх)-ийг илгээх асуудал багтана.

(2) Шаардлагатай үед Хэлэлцэн тохирогч аль нэг Тал "ГҮХТ баг"-ийг хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт илгээх хүсэлтийг нөгөө Талдаа гаргаж болно. "ГҮХТ баг"-ийн алба хаагчдыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хэсэгчилсэн даалгавар гүйцэтгүүлэхээр илгээхдээ өөрийн улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авна.

(3) Хэрэв "ГҮХТ баг", эсхүл түүний алба хаагчид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр ажиллагаа гүйцэтгэх бол "ГҮХТ баг"-ийн алба хаагчид нь Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэр дээрх алба хаагчдаас хамтран ажиллахыг хүсэх эрхтэй.

(4) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын "ГҮХТ баг"-ийг ажиллуулах хүсэлт гаргасан Хэлэлцэн тохирогч Тал нь журамд заасны дагуу өөрийн алба хаагчийг уг багт орж ажиллах явдлыг хангана.

(5) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр ажиллагаа гүйцэтгэж буй "ГҮХТ баг"-ийн алба хаагчид өөрийн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу таних тэмдэг заавал зүүнэ.


(6) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын алба хаагч бус боловч "ГҮХТ баг"-ийн энгийн гишүүд болох шинжээчдийг энэ зүйлд заасан хамтын ажиллагааны зорилгоор Хэлэлцэн тохирогч Талын алба хаагчид мөн тооцно. Энэхүү хэлэлцээрийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн сүүлийн өгүүлбэр, мөн 20.3 болон 20.5 дахь хэсгүүд эдгээр алба хаагчдад хамаарахгүй.

IV ДЭХ ХЭСЭГ

Эрх зүйн харилцаа

17 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн дагуу хувийн мэдээллийг шилжүүлэх бол тухайн мэдээллийг ашиглахад дараах заалтууд хамаарна. Үүнд:



(a) Хувийн мэдээлэл хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь тухайн хувийн мэдээллийг зөвхөн шилжүүлэн авсан зорилгынхоо хүрээнд болон шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талын тавьсан нөхцөлийн дагуу ашиглаж болно. Түүнчлэн тухайн хувийн мэдээллийг энэхүү Хэлэлцээрийн хүрээнд зөвшөөрөх бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөн олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талаас тавьсан нөхцөлийн дагуу ашиглана. Хувийн мэдээллийг шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч талын зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр тухайн хувийн мэдээллийг өөр бусад зорилгоор ашиглаж болно.


(b) Шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Талд хүсэлт гаргавал хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нь тухайн хувийн мэдээллийг хэрхэн ашигласан болон түүнээс гарсан үр дүнг мэдээлнэ.

(c) Шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Тал нь тухайн хувийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, мөн шилжүүлэх нь хүссэн зорилгод нийцсэн, шаардлагатай эсэхийг шалгах үүрэгтэй. Шилжүүлэн өгсөн хувийн мэдээлэл нь шилжүүлэн өгсний дараа алдаатай, эсхүл шилжүүлэн өгөх шаардлагагүй болох нь тогтоогдсон тохиолдолд энэ талаар хувийн мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд даруй заавал мэдэгдэнэ. Хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал алдаатай хувийн мэдээллийн алдааг засварлах, эсхүл шилжүүлэн авах шаардлагагүй байсан хувийн мэдээллийг устгана.

(d) Хүсэлт гаргавал тухайн хувийн мэдээлэлд холбогдох этгээдэд энэхүү Хэлэлцээрийн дагуу шилжүүлэн өгсөн, эсхүл боловсруулсан хувийн мэдээллийн талаар, мөн тухайн мэдээллийг ашиглах зорилгын талаарх мэдээллийг заавал гаргаж өгнө. Дээр дурдсан зүйл нь үндэсний хууль тогтоомжийн дагуу олон нийтийн ашиг сонирхлын үүднээс тухайн мэдээллийг шилжүүлэн өгөхгүй байх нь уг мэдээллийг олж авах тухайн хувь хүний ашиг сонирхлыг хөндөхгүй байх тохиолдолд хамаарна.

(e) Энэ зүйлийн "d" хэсэгт дурдсан асуудлаар гаргасан хүсэлтийг шийдвэрлэхээс өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагын саналыг байнга авна. Хувийн мэдээлэлд холбогдох этгээдийн хүсэлтийг шийдвэрлэх Хэлэлцэн тохирогч Тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр тухайн этгээдэд мэдээлэхгүй. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн мэдээллийг хувь этгээдэд өгөхгүй байхыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талаас хүсэж болно. Бусад тохиолдолд өөрийн хувийн мэдээллийг олж авах хувь хүний эрхийг тухайн хувь хүний гаргасан хүсэлтийг шийдвэрлэх Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

(f) Мэдээлэлд хамаарах этгээд нь шилжүүлэн өгсөн өөрийн хувийн мэдээлэлд засвар оруулах, мөн нэмэлт мэдэгдэл гаргах хэлбэрээр дутуу мэдээллийг бүрэн болгох тухай хүсэлт гаргах эрхтэй. Дээр дурдсан зүйл нь үндэсний хууль тогтоомжийн дагуу олон нийтийн ашиг сонирхлын үүднээс уг мэдээлэлд засвар



оруулахаас татгалзах, эсхүл татгалзсан шалтгааныг тайлбарлахгүй байх нь тухайн хувь хүний ашиг сонирхлыг хөндөхгүй тохиолдолд хамаарна. Энэ зүйлийн "е" хэсэг энэ тохиолдолд нэгэн адил хэрэглэгдэнэ.

(g) Хэрэв шилжүүлэн өгсөн мэдээллийг тухайн мэдээлэлд хамаарах этгээдийн эрх болон хамгаалагдсан ашиг сонирхлын эсрэг буюу хувийн мэдээллийг зөвхөн автоматаар боловсруулахад ашигласан бол тухайн хувь этгээд хувийн мэдээллийг боловсруулах зорилго, хэлбэрийг тодорхойлох асуудал хариуцсан эрх бүхий байгууллагаас өөрийн оролцоог хангуулах эрхтэй.

(h) Шилжүүлэн өгсөн хувийн мэдээлэлд зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд хүний арьсны өнгө, үндэс, угсаа, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, эсхүл философийн итгэл үнэмшил, эсхүл үйлдвэрчний эвлэлийн байгууллагад гишүүнчлэлтэй эсэх талаар болон генетикийн болон биеийн давхцахгүй өгөгдөл болох биометрийн, эрүүл мэнд, бэлгийн амьдрал буюу бэлгийн чиг хандлагын талаарх мэдээллийг тусгахыг зөвшөөрнө.


(i) Хувийн мэдээллийг шилжүүлэн өгөхдөө шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Тал үндэсний хууль тогтоомжийн дагуу тухайн хувийн мэдээллийг устгах эцсийн хугацааг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд тогтоож болно. Энэхүү хугацаанаас үл хамааран шилжүүлэн өгсөн хувийн мэдээллийг шилжүүлэн өгсөн зорилгод дурдсаны дагуу ашиглагдахаа больсон даруйд устгана. Хувийн мэдээллийг шилжүүлэн өгсөн болон хүлээн авсан эрх бүхий байгууллагууд нь хувийн мэдээллийг шилжүүлэх, хүлээн авах болон устгах талаар бүртгэл хөтлөх үүрэгтэй.

(j) Хувийн мэдээллийг шилжүүлэн авсан Хэлэлцэн тохирогч тухайн Талын эрх бүхий байгууллага нь өөрийн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу зохих журмаар байгууллагынхаа холбоо барих мэдээлэл, хувийн мэдээллийг боловсруулах зорилгын талаар болон энэ зүйлийн "d-g" хэсэгт заасан тухайн мэдээлэлд хамаарах этгээдийн эрхийн талаар, мөн үндэсний хууль тогтоомжийн дагуу тэдгээрийн хувийн нууц болон хувь хүний мэдээллээ хамгаалуулах эрхийг хангах захиргааны болон шүүхийн хамгаалалтын талаар мэдээлнэ.

(k) Хэлэлцэн тохирогч Талууд харилцан шилжүүлэн авсан хувийн мэдээлэлд санамсаргүй байдлаар болон зөвшөөрөлгүй нэвтрэх, уг мэдээллийг санамсаргүй байдлаар болон зөвшөөрөлгүй шилжүүлэх, засварлах, задруулахаас сайтар хамгаалах үүрэгтэй. Үүний тулд талууд ялангуяа энэ зүйлийн "h" хэсэгт заасан хувийн мэдээллийг хамгаалах чиглэлээр зохих техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авна.

18 дугаар зүйл

(1) Нууц мэдээллийг шилжүүлэх болон харилцан хамгаалахтай холбогдох харилцааг зохицуулсан тусгайлсан хэлэлцээр байгуулахаас бусад тохиолдолд



үндэсний хууль тогтоомжийн дагуу энэхүү Хэлэлцээрийн хүрээнд нууц мэдээллийг шилжүүлэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд дор дурдсаныг баримтална. Үүнд:

(a) Тухайн мэдээлэл нь шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу нууцын зэрэглэлд хамаарч, зохих тэмдэглэгээтэй тохиолдолд уг мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал өөрийн үндэсний хууль тогтоомжид заасан нууцын зохих зэрэглэлтэй ижил түвшинд буюу энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад заасан нууцын зэрэглэлийн түвшинтэй дүйцэх хэмжээнд хамааруулан үзэж, хамгаална.

(b) Нууц мэдээллийг шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Тал тухайн нууц мэдээллийн нууцлалд аливаа өөрчлөлт орсон, эсхүл нууцлалаас гарсан тохиолдолд энэ талаар нууц мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талд даруй бичгээр мэдэгдэнэ. Нууц мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нууц мэдээллийн нууцлалд орсон өөрчлөлтийг, эсхүл нууцлалаас гаргах ажлыг хойшлуулшгүйгээр гүйцэтгэнэ.


(c) Хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал нууц мэдээллийг зөвхөн хүлээн авсан зорилгын хүрээнд болон шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Талын тавьсан нөхцөлийн дагуу ашиглаж болно. Шилжүүлэн авсан нууц мэдээллийг шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талын зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр өөр бусад зорилгоор ашиглаж болно.

(d) Шилжүүлсэн нууц мэдээлэл нь хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу гагцхүү зөвшөөрөл авсан, мэдэх шаардлагатай этгээдэд, тухайлбал нууц мэдээллийн зохих зэрэглэл бүхий нууц мэдээлэлтэй танилцах шаардлагыг хангасан тохиолдолд танилцуулж болно.

(e) Шилжүүлсэн нууц мэдээлэлтэй энэхүү Хэлэлцээрт заасны дагуу хамтран ажиллах эрх бүхий байгууллагаас гадна өөр эрх бүхий байгууллага болон гэмт хэрэгтэй тэмцэх бусад эрх бүхий байгууллагуудад нууц мэдээллийг шилжүүлэн өгсөн Хэлэлцэн тохирогч Талын зөвхөн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр танилцуулж болно.

(f) Шилжүүлэн авсан нууц мэдээллийг хамгаалахтай холбоотой хүлээн авсан Хэлэлцэн тохирогч Тал үндэсний хууль тогтоомжоо зөрчсөн бол энэ тухайгаа нууц мэдээллийг шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Талд даруй мэдэгдэх ба уг мэдэгдэлд үндэсний хууль тогтоомж зөрчсөн нөхцөл байдал, гарах үр дагавар, түүнийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон цаашид үндэсний хууль тогтоомжийн дагуу энэ төрлийн зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх мэдээллийг тусгана.

(2) Хэлэлцэн тохирогч Талуудын тогтоосон харилцах сувгаар нууц мэдээллийг шууд шилжүүлж болно.



(3) Хэлэлцэн тохирогч Талууд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан холбоо барих сувгуудын талаар энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс оройтолгүй харилцан бие биедээ дипломат шугамаар мэдэгдэнэ.

19 дүгээр зүйл

(1) Шилжүүлэн авсан мэдээлэл болон материалыг шилжүүлсэн Хэлэлцэн тохирогч Талын зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр гуравдагч улсууд болон олон улсын байгууллагуудад өгч болно.


(2) Энэхүү Хэлэлцээрийн дагуу Чехийн тал хамтын ажиллагааны хүрээнд Монголын талаас шилжүүлсэн мэдээллийг Монголын тал тодорхой нөхцөлд татгалзахаас бусад тохиолдолд Европын Холбооны хууль тогтоомжийн дагуу олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хангах, мөн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор бий болгосон мэдээллийн системийг ашиглахдаа тухайлбал "Шенгений орнуудын мэдээллийн систем"-ийг ашиглах явцдаа Европын Холбооны бусад гишүүн орнууд болон энэхүү системд нэвтрэх зөвшөөрөлтэй бусад орнууд, Европын Холбооны агентлагуудтай хуваалцаж болно.

20 дугаар зүйл

(1) Энэхүү Хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэж буй алба хаагчид нь Хэлэлцэн тохирогч тухайн Талын үндэсний хууль тогтоомжид захирагдана. Энэхүү Хэлэлцээрийн III хэсэгт заасан хамтын ажиллагааны тусгай хэлбэрүүдээс бусад тохиолдолд тэдгээр алба хаагчид ямар ч эрх эдлэхгүй.

(2) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа алба хаагчид нь өөрсдийн дүрэмт хувцсыг өмсөж болох ба ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах галт зэвсэг, хамгаалах хэрэгсэл, албадлагын хэрэгсэл, мөн Хэлэлцэн тохирогч тухайн Талын үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрдөг байлдааны бусад хэрэгслийг тэдгээр алба хаагчдын ажиллагаа гүйцэтгэж байгаа нутаг дэвсгэр бүхий Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллагын зүгээс зөвхөн тодорхой тохиолдолд өмсөхийг, биедээ авч явахыг хориглосон, эсхүл зөвшөөрснөөс бусад тохиолдолд ашиглаж болно. Энэхүү Хэлэлцээрийн дагуу ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай тохиолдолд тэдгээр алба хаагчид нь байрлаж буй нутаг дэвсгэр бүхий Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу бусад тоног төхөөрөмж, албаны нохой, уналганы морьтой байж, мөн ашиглаж болно.

(3) Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан алба хаагчид нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах өөрсдийн галт зэвсэг, албадлагын хэрэгслийг зөвхөн шаардлагатай хамгаалалтын үед, эсхүл онцгой нөхцөл байдлын үед ашиглаж болно. 12 дугаар зүйлд заасны дагуу



ажиллагаанд дайчлагдсан алба хаагчид тухайн ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах галт зэвсэг, албадлагын хэрэгслийг тодорхой тохиолдолд тэдгээрийг шууд хариуцсан алба хаагчаас өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр дурдсанаас өөрөөр ашиглаж болно.

(4) Энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэж буй алба хаагчид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын алба хаагчдын нэгэн адил нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрөөс чөлөөлөгдөнө.

(5) Энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэж буй алба хаагчид гэмт хэрэг үйлдсэн, эсхүл тэдний эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд уг асуудлыг Хэлэлцэн тохирогч тухайн Талын алба хаагчдын нэгэн адил авч үзнэ.

(6) Үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэж буй алба хаагчид тэдгээрийг харьяалах Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомж, ялангуяа сахилгын дүрэм болон тэдгээрийн хариуцлагыг тогтоосон дүрэмд захирагдана.

(7) Хэлэлцэн тохирогч аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын илгээсэн алба хаагчдыг хамгаалах, өөрийн алба хаагчдын нэгэн адил дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

21 дүгээр зүйл


(1) Энэхүү хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэж буй алба хаагчдад шаардлагатай тохиолдолд тухайн ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах өөрсдийн авто тээврийн хэрэгсэл болон нисэх онгоцыг авч ирэх болон ашиглахыг зөвшөөрнө. Энэ тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын алба хаагчдын нэгэн адил дүрэмд захирагдана.

(2) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагааг гүйцэтгэхэд шаардагдах авто тээврийн хэрэгсэл нь зам болон хурдны зам ашигласны төлбөрөөс Хэлэлцэн тохирогч тухайн Талын алба нэгэн адил чөлөөлөгдөнө.

(3) Нисэх онгоцнуудыг холбогдох газар оронд байрлуулахад илгээсэн улсаасаа холбогдох зөвшөөрлийг зайлшгүй авсан байна.

22 дугаар зүйл

(1) Хэлэлцэн тохирогч нөгөө Талын алба хаагч энэхүү Хэлэлцээрийн дагуу ажиллагаа гүйцэтгэх явцад хохирол учруулсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд тэдгээрийн эд хөрөнгийг үрэгдүүлсэн, эсхүл эвдсэний улмаас учирсан хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэхээс татгалзана.



(2) Энэхүү Хэлэлцээрийн дагуу ажиллагаа гүйцэтгэх явцад Хэлэлцэн тохирогч Талуудын алба хаагч гэмтэж бэртсэн, эсхүл нас барсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд учирсан хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэхээс татгалзана. Энэ нь тухайн алба хаагч, эсхүл уг алба хаагчийн гэр бүлийн бусад гишүүд учирсан хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэхэд нөлөөлөхгүй.

(3) Хохирлыг санаатайгаар болон илтэд хайхрамжгүй байдлын улмаас учруулсан тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэг болон 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрт тусгасан асуудал хамаарахгүй.


(4) Хэлэлцэн тохирогч нэг Талын алба хаагч энэхүү Хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэх явцдаа гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд тухайн нутаг дэвсгэр бүхий Хэлэлцэн тохирогч Тал өөрийн улсын алба хаагчийн учруулсан хохирлын нэгэн адил авч үзэж үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирлыг хариуцна. Тухайн Хэлэлцэн тохирогч Талын нөхөн төлсөн нийт төлбөрийн дүнг хохирол учруулсан алба хаагчийг харьяалах Хэлэлцэн тохирогч Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талд буцаан олгоно. Энэ хэсгийн 2 дахь өгүүлбэр нь 12 дугаар зүйлд заасан байрлаж буй алба хаагчдыг хариуцсан алба хаагчийн зааварчилгааны дүнд учирсан хохирлын асуудалд хамаарахгүй.

(5) Энэхүү Хэлэлцээрийн дагуу хамтын ажиллагааны хүрээнд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гуравдагч этгээдийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний улмаас Хэлэлцэн тохирогч нэг Талын эд хөрөнгөд хохирол учирсан хохиролд тухайн нутаг дэвсгэр бүхий Хэлэлцэн тохирогч Тал үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирлыг нэхэмжилнэ. Нөхөн төлбөрийг эд хөрөнгөд нь хохирол учирсан Хэлэлцэн тохирогч талд шилжүүлнэ.

(6) Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд хамтын ажиллагааны тодорхой хэлбэрүүдийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө энэ зүйлийн заалтуудаас татгалзаж болно.

23 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, эсхүл Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд өөрөөр тохиролцоогүй бол Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн эрх бүхий байгууллагуудын энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан зардлыг өөрөө хариуцна; Хэлэлцэн тохирогч Талууд зардлын тухайд харилцан тэнцүү, ашигтай байдлыг харгалзан үзнэ.



V ХЭСЭГ

Төгсгөлийн заалтууд

24 дүгээр зүйл

Өөрөөр тохиролцоогүй бол Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ англи хэлийг ашиглана.

25 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын Засгийн газар, цаашилбал Монголын талаас Хууль зүй, дотоод хэргийн яам, Чехийн талаас Дотоод хэргийн яам болон Сангийн яам шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжилтийн тохиролцоо байгуулж болно.

26 дугаар зүйл


Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлахтай холбогдуулан гарсан аливаа маргааныг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

27 дугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын заавал дагаж мөрдөх олон улсын бусад хоёр талт болон олон талт гэрээгээр хүлээсэн үүргийг хөндөхгүй.

28 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал үндэсний аюулгүй байдал, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам, эсхүл бусдын эрүүл мэндийг хангах үүднээс шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хэсэгчлэн эсхүл бүхэлд нь түр зогсоож болно. Хэлэлцэн тохирогч Талууд энэ төрлийн арга хэмжээг авсан эсхүл цуцалсан даруйд энэ талаар харилцан бие биедээ дипломат шугамаар мэдэгдэнэ. Энэхүү Хэлэлцээрийг түдгэлзүүлсэн болон уг түдгэлзүүлсэн шийдвэрээ цуцалсан тухай шийдвэр нь тухайн мэдэгдэлд заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжих ба энэхүү мэдэгдлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд уг мэдэгдлийг хэрэгжиж эхлэх өдрөөс арван таваас дээшгүй өдрийн өмнө хүргүүлнэ. Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг түдгэлзүүлэхээс өмнө шилжүүлэн өгсөн хувийн мэдээлэлтэй ажиллах, мөн мэдээлэл болон материалыг гуравдагч улсууд болон



олон улсын байгууллагуудад шилжүүлэхэд энэхүү Хэлэлцээрийн заалтууд үргэлжлэн үйлчилнэ.

29 дүгээр зүйл


(1) Энэхүү Хэлэлцээр Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгохтой холбоотой үндэсний хууль тогтоомжийн дагуу дотоодын хуулийн шаардлагаа хангасан тухай бичгээр харилцан бие биедээ дипломат шугамаар мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш хоёр дахь сарын эхний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.

(2) Энэхүү Хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулсан болно. Энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг Хэлэлцэн тохирогч аль нэг Тал бичгээр дипломат шугамаар мэдэгдсэнээр дуусгавар болгож болно. Хэлэлцэн тохирогч нөгөө Талд энэхүү мэдэгдлийг хүргүүлсэн өдрөөс хойш зургаан сарын дараа энэхүү Хэлэлцээрийн үйлчлэл дуусгавар болно. Энэхүү Хэлэлцээрийн заалтууд Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Хэлэлцээрийн дагуу шилжүүлэн өгсөн хувийн мэдээлэлтэй ажиллах, түүнийг устгах хүртэл үйлчилнэ. Энэхүү Хэлэлцээрийн дагуу шилжүүлэн өгсөн нууц мэдээллийг хэлэлцээрийн 18 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцээрийн үйлчлэл дуусгавар болсны дараа ч тухайн нууц мэдээллийг хүлээн авсан Хэлэлцэн тохирогч талыг тухайн үүргээс чөлөөлөх хүртэл хамгаална.

Энэхүү хэлэлцээрийг хотноо оны дугаар сарын -ны өдөр монгол, чех, англи хэлээр тус бүр хоёр хувь байгуулсан ба эх бичвэр тус бүр адил хүчинтэй байна. Тайлбарлах үед зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ



**Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай
Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн
Хавсралт**

Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу, холбогдох үндэсний хууль тогтоомжийг анхааралдаа авсны үндсэн дээр Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор нууцлалын талаар дараах зэрэглэлийг дүйцүүлэн тогтоосон болно. Үүнд:

Монгол Улсын хувьд	Бүгд Найрамдах Чех Улсын хувьд	Англи хэлээр дүйцүүлэн тогтоосон
Ийм зэрэглэл байхгүй	VYHRAZENÉ	RESTRICTED
НУУЦ	DÜVERNÉ	CONFIDENTIAL
МАШ НУУЦ	TAJNÉ	SECRET
ОНЦ ЧУХАЛ НУУЦ	PRISNĚ TAJNÉ	TOP SECRET

Энэхүү Хэлэлцээрийн дагуу Чехийн талаас шилжүүлэн өгсөн "VYHRAZENÉ (RESTRICTED)" гэсэн тэмдэглэгээтэй нууцын зэрэглэл бүхий мэдээллийг Монголын тал "НУУЦ" гэсэн зэрэглэлийн нэгэн адил авч үзэн хамгаалах үүрэгтэй.

Чехийн талын "VYHRAZENÉ (RESTRICTED)" гэсэн тэмдэглэгээтэй нууцын зэрэглэл бүхий мэдээллийн хариуд Монголын тал хариу өгөхдөө тухайн хариу мэдээллийн эхний хэсэгт англи хэлээр: "REPLY TO A DOCUMENT ORIGINALLY MARKED AS "RESTRICTED" BY THE CZECH REPUBLIC (БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН "RESTRICTED" ГЭСЭН ТЭМДЭГЛЭГЭЭТЭЙ НУУЦЫН ЗЭРЭГЛЭЛ БҮХИЙ БАРИМТ БИЧГИЙН ХАРИУ)" гэсэн өгүүлбэрийг бичсэн байх ба ингэснээр Чехийн тал үүнийг "VYHRAZENÉ" гэсэн тэмдэглэгээтэй нууцын зэрэглэл бүхий мэдээллийн хариу гэж ойлгоно. Дээрх өгүүлбэрийг бичээгүй байх аваас уг хариуг дээр дурдсан нууцын зэрэглэлийг дүйцүүлэн тогтоосон хүснэгтэд заасан зохих зэрэглэлд хамааруулан авч үзнэ.

Хэлэлцэн тохирогч Талууд нууцын зэрэглэл бүхий мэдээллийг харилцан шилжүүлэн өгөхдөө тухайн мэдээлэлд нууцын зохих зэрэглэлийг илэрхийлэх тэмдэглэгээг хоёр хэлээр буюу англи хэлээр болон өөрийн эх хэлээр үйлдсэн байна.

---000---





**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ**

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2026 он

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Агуулга

Нэг. Асуудалд дүн шинжилгээ хийх

- 1.1. Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ
- 1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд
- 1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Хоёр. Асуудлыг шийдвэрлэх зорилго

- 2.1. Гол зорилго, зорилт

Гурав. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

- 3.1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоох
- 3.2. Зохицуулалтын хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах
- 3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарыг сонгох

Дөрөв. Зохицуулалтын хувилбарын үр нөлөө

- 4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө
 - 4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө
 - 4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- 4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх

Тав. Зохицуулалтуудын хувилбаруудын харьцуулалт

Зургаа. Дүгнэлт, зөвлөмж

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1.1. Тулгарч байгаа асуудал, түүний мөн чанар, цар хүрээ:

Дэлхийн улс орнууд даяаршиж, нэгдмэл болохын хэрээр аюул занал ч мөн нийтлэг шинж чанартай болж байгаатай холбогдуулан ихэнх улс орнууд бүс нутгийн аюулгүй байдлын орчин нөхцөл, хамтын хамгаалах тогтолцоог буй болгоход түлхүү анхаарч байна.

Улс орнуудад үндэстэн дамнасан зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн үйлдлийн арга, зохион байгуулалтын хэлбэрийг илрүүлэх, таслан зогсооход хүндрэл учирч, нэг улсын хил хязгаараас давж, улс орон дамжин үйлдэгдэх хандлага нэмэгдэж, хэд хэдэн улсын цагдаагийн байгууллага хамтран гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэрэгцээ, шаардлага нэмэгдсээр байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл (*Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх*)-ийн 7.2 дахь хэсэгт¹ “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:” гээд 7.2.4 дэх заалтад “... Хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх;” гээд мөн хуулийн 25 дугаар зүйл (*Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засгийн газрын бүрэн эрх*)-ийн 25.1 дэх хэсэгт “Засгийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 25.1.9 дэх заалтад “... Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэргэшсэн нэгж, мэргэжилтэн бэлтгэх” гэж зохицуулсан.

Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйл (*Цагдаагийн төв байгууллагын үүрэг*)-ийн 14.2 дахь хэсэгт² “Цагдаагийн төв байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд дараах үүрэг гүйцэтгэнэ:” гээд 14.2.5 дахь заалтад “... өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улсын цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрээс хүлээн авсан мэдээ, мэдээллээр цагдаагийн байгууллагыг хангах;” гэж заасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2030 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.2.20-д “Хилийн чанад дахь Монгол Улсын иргэд гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллана.”³ гэж тус тус тусгажээ.

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=14700>

² <https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawid=17141368141311>

Энэ хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс монголчууд ихээр зорчиж, амьдарч, мөн ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор оршин сууж буй улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ, хэлэлцээр байгуулах асуудалд анхаарал хандуулан ажиллаж байна.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд:

Монгол Улсын хэмжээнд зохион байгуулалттай арга хэлбэрээр үйлдэгдэж буй, тэр дундаа хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 2023 онд 238, 2024 онд 252, 2025 онд 305 тус тус бүртгэгдсэн бөгөөд 2024 онтой харьцуулахад 21 хувиар (*тоогоор 53*) өссөн үзүүлэлттэй байна.

Харин кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухайд 2023 онд 388, 2024 онд 406, 2025 онд 793 тус тус бүртгэгдсэн бөгөөд мөн адил 2024 онтой харьцуулан авч үзэхэд 95.3 хувиар (*тоогоор 387*) өссөн үзүүлэлттэй байгаа⁴ нь эдгээр төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр бүс нутгийн төдийгүй олон улсын цагдаа, хууль сахиулах байгууллагуудтай түргэн, шуурхай хамтран ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгож байгаа юм.

Мөн цахим орчинд үйлдэгдэж буй хууль бус мөрийтэй тоглоом, луйвар, садар самууныг сурталчлах, олон нийтийн сүлжээнд хуурамч, хаалттай группүүдийг олноор нээж иргэдээс урьдчилгаа төлбөр авч, зүй бус бичлэг хийж зарах, бүртгэлгүй дугаар ашиглан зар байрлуулан бусдын биеийг үнэлүүлэх зэргээр хүн худалдаалах гэмт хэрэг зохион байгуулалттай, далд хэлбэрт шилжиж, гэмт хэргийн гаралт, насанд хүрээгүй хохирогчдын тоо жил бүр өсөн нэмэгдэж байна.

Үүнээс гадна энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэр нь зүүн Европын улс орнууд болох Албани, Серби зэрэг орнуудын гэмт бүлэглэлүүдийн үйлдлийн арга, хэлбэртэй төстэй байдлаар үйлдэгдэж байгаа нь анхаарал татаж байгаа тул Чех Улстай энэ чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх нь иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

1.3. Тухайн асуудал үүссэн шалтгаан, нөхцөл:

Манай улсын иргэдийн гадаад улсад зорчих тоо жил ирэх тусам тогтмол өсөж байгаатай холбоотойгоор гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хууль ёсны эрх ашиг нь зөрчигдөх явдал тодорхой хэмжээнд нэмэгдсээр байна.

⁴ “Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” товхимол (2024 он, 2025 он, 2026 он).

Тухайлбал, сүүлийн гурван жилийн байдлаар манай улсын 260 мянга орчим иргэн хилийн чанадад ажил хөдөлмөр эрхлэх, суралцах зэрэг зорилгоор оршин сууж байгаагаас 2025 оны 12 дугаар сарын байдлаар манай улсын 14 200 орчим иргэн Бүгд Найрамдах Чех Улсад дээрх зорилгоор оршин сууж байна.⁵

Харин энэ оны 2 дугаар сарын байдлаар Бүгд Найрамдах Чех Улсын 36 иргэн манай улсад ажил хөдөлмөр эрхлэх, суралцах болон бусад зорилгоор оршин сууж байна гэсэн статистик мэдээлэл байна.⁶

Энэхүү “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны түвшинд дагнан байгуулсан анхны хоёр талт олон улсын гэрээ бөгөөд Чех Улсаар дамжуулан Европын Холбооны 27 улсад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх түргэн шуурхай мэдээлэл солилцоход энэхүү хэлэлцээр чухал ач холбогдолтой баримт бичиг юм.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тодорхой ажиллагааг хоёр улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх боломжтой болох бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломж бүрдэнэ.

Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах замаар гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар, мэдүүлэг авахын зэрэгцээ талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох боломжтой юм.

Түүнчлэн талуудын эрх бүхий байгууллагуудын алба хаагчид хэлэлцэн тохирогч нөгөө улсын нутаг дэвсгэрт ажиллагаа гүйцэтгэх, ингэхдээ өөрсдийн биедээ авч ирсэн галт зэвсэг, сум, бусад тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, агаарын хөлөг, албаны нохой, уналга морь зэргийг ашиглах боломжтой ба талуудын

⁵ Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээлэл (2025 он, 2026 он)

⁶ Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээлэл (2026 оны 2 дугаар сар)

эрх бүхий байгууллагууд “Гамшгийн үеийн хохирогчийг тодорхойлох баг”-ийг нөгөө улсын нутаг дэвсгэрт харилцан томилох замаар тодорхой төрлийн ажиллагааг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна.

Дээр дурдсан хамтын ажиллагааны төрөл, хэлбэрүүдээс гадна талууд сургалтын чиглэлээр хамтран ажиллах буюу хамтарсан сургалт, семинар, дадлага, сургуулилт, хэлний сургалт зохион байгуулах, мэргэжилтнүүдийг сургах ба үүнд тодорхой ажилтныг томилон оролцуулах, сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулахад мэргэжлийн түвшний шинжээчдийг харилцан оролцуулах, дадлага, сургуулилтад ажиглагчдыг оролцуулах боломж мөн бүрдэх юм.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

3.1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоох:

Хүснэгт 1. Асуудлыг зохицуулах хувилбарууд, тэдгээрийн тайлбар

Д/д	Асуудлыг зохицуулах хувилбар	Хувилбарыг сонгох эсэх	Хувилбарын тайлбар
1.	“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Үгүй	Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тодорхой ажиллагааг хоёр улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх боломжтой болох бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломж бий болох тул “тэг” хувилбар сонгох боломжгүй байна.

2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Үгүй	Тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхүйц арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хэвлэл, мэдээлэл, бусад арга хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга, сурталчилгааны ажил явуулах боломжгүй байх тул энэхүү хувилбарыг сонгох боломжгүй байна.
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Үгүй	Энэ төрлийн харилцаа буюу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны асуудлыг төрөөс зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан зохицуулалт хийх боломжгүй тул энэхүү хувилбарыг сонгох боломжгүй байна.
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Үгүй	Төрөөс санхүүгийн интервенц хийх арга замаар энэ төрлийн харилцааг зохицуулах боломжгүй байх тул энэхүү хувилбарыг сонгох боломжгүй байна.
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Үгүй	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд холбогдох асуудлыг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх нь зарчмын хувьд боломжгүй тул энэхүү хувилбарыг сонгох боломжгүй байна.
6.	Захиргааны шийдвэр гаргах	Үгүй	Энэхүү хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул энэхүү хувилбарыг сонгох боломжгүй байна.
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Тийм	Энэхүү хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул энэхүү хувилбарыг сонгох юм.

Дээрхээс үзэхэд “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах”, “хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг

соён гэгээрүүлэх”, “зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх”, “төрөөс санхүүгийн интервенц хийх”, “төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх”, “захиргааны шийдвэр гаргах” гэсэн хувилбарууд нь тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэхүйц тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд төдийлөн үр дүнтэй биш байх тул дурдсан асуудлуудыг хууль тогтоомжийн төсөл боловсруулан шийдвэрлэх нь зорилгод хүрэх үр нөлөөтэй хувилбар гэж үзлээ.

3.2. Зохицуулалтын хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах:

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулсан харьцуулалтыг дор харууллаа. Үүнд:

Хүснэгт 2. Асуудлыг зохицуулах хувилбарын харьцуулалт

Сонгож авсан хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Энэхүү хэлэлцээрээр дамжуулан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.	Чехийн талаас хүсэлт хүлээн авсан тохиолдолд 1 хүсэлтийг гүйцэтгэхэд зарцуулах бичиг хэрэг болон шуудангийн дундаж зардалд 17,768 төгрөгийн зардал шаардагдах урьдчилсан тооцоолол гарч байгаа хэдий ч нөгөө талаас эрх зүйн туслалцаа үзүүлэх замаар иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.	Үр дүнтэй хувилбар гэж үзэж байна.

3.3. Хамгийн үр дүнтэй хувилбарыг сонгох:

Сонгож авсан хувилбар болох “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа талаас нь авч үзэхэд хэлэлцээрт тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамгийн үр дүнтэй хувилбар болох нь харагдаж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨ

Сонгож авсан хувилбар болох “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарын үр нөлөөг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын⁷ 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын⁸ 6.2-т “Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа дор дурдсан суурь асуултуудыг ашиглана” гэж заасны дагуу дор дурдсан ерөнхий асуултуудад хариулах арга замаар нэгдсэн дүгнэлтийг хийлээ. Үүнд:

4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө:

Хүснэгт 3. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Үгүй	Хуулийн төсөлд ялгаварлан гадуурхахтай холбогдсон зохицуулалт тусгагдаагүй болно.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Хуулийн төсөлд ялгаварлан гадуурхахтай болон аль нэг бүлэгт давуу байдал олгосонтой холбогдсон зохицуулалт тусгагдаагүй болно.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Үгүй	Хуулийн төсөлд зохицуулсан харилцаа нь тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ биш болно.

⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11993>

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207333&showType=1>

1.2.Оролцоог хангах		
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Үгүй	Хуулийн төсөлд эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг тодотгосонтой холбогдсон зохицуулалт тусгагдаагүй болно.
1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Үгүй	Хуулийн төсөлд оролцогч бүлгүүдтэй тусгайлан холбогдсон зохицуулалт тусгагдаагүй болно.
1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага		
1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Хуулийн төслийг баталснаар иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад тодорхой хэмжээнд үр дүн гарна гэж үзэж байна.
1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төсөлд тусгасан зохицуулалт нь хүний эрхийн талаарх суурь зохицуулалт, Монгол Улсын олон улсын гэрээ болон хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа болно.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Үгүй	Хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлах явцад үүсэх аливаа маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэхээр хэлэлцээрт тусгасан.

2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	Хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөг аливаа хэлбэрээр хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй болно.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөг аливаа хэлбэрээр хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй болно.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Хоёр улсын Засгийн газар буюу Монголын талаас Хууль зүй, дотоод хэргийн яам, Чехийн талаас Дотоод хэргийн яам байхаар тодорхойлсны зэрэгцээ талуудын цагдаагийн байгууллагуудыг тусгаж өгсөн болно.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Үгүй	Хуулийн төсөлд эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт тусгагдаагүй болно.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Үгүй	Хуулийн төсөлд эмзэг бүлэг, тэдгээрийн нөхцөл байдлыг тодотгосон зохицуулалт тусгагдаагүй болно.

	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Үгүй	Хуулийн төсөлд эмзэг бүлэг, тэдгээрийн ялгаатай хэрэгцээг тодотгосон зохицуулалт тусгагдаагүй болно.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Хоёр улсын Засгийн газар буюу Монголын талаас Хууль зүй, дотоод хэргийн яам, Чехийн талаас Дотоод хэргийн яам байхаар тодорхойлсны зэрэгцээ талуудын цагдаагийн байгууллагуудыг тусгаж өгсөн болно.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд жендэрийн эрх тэгш байдлын талаарх зохицуулалт тусгагдаагүй болно.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төсөлд хүйсээр ялгаварласан, хүний тэгш эрх, тэгш боломжийг хязгаарласан аливаа зохицуулалт тусгагдаагүй болно.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Чехийн талаас ирүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлтийн нийт тоог тодорхой гаргах боломжгүй ба хүсэлт хүлээн авсан тохиолдолд 1 хүсэлтийг гүйцэтгэхэд зарцуулах бичиг хэрэг болон шуудангийн дундаж зардалд 17,768 төгрөгийн зардал шаардагдах урьдчилсан тооцоолол гарч байна.

Мөн энэхүү хэлэлцээрийн дагуу Чехийн талын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхтэй холбогдуулан хэрэг бүртгэх,

мөрдөн байцаах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад шинээр ажлын байр бий болгохгүй, орон тоо нэмэхгүй учраас дээр дурдсан 28,675 төгрөгийн цалингийн зардал нэмж гарахгүй. Түүнчлэн иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад тодорхой хэмжээнд үр дүнтэй юм.

Хүснэгт 4. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө, тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

	хязгаарлалт бий болгох эсэх		
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

	багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар Чехийн талаас хүсэлт хүлээн авсан тохиолдолд 1 хүсэлтийг гүйцэтгэхэд зарцуулах бичиг хэрэг болон шуудангийн дундаж зардалд 17,768 төгрөгийн зардал шаардагдах урьдчилсан тооцоолол гарсан хэдий ч улсын төсөвт аливаа сөрөг үр нөлөө үзүүлэхгүй болно.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага гарахгүй ба одоогийн бүтцээр ажиллах бүрэн боломжтой болно.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар захиргааны шинэ чиг үүрэг бий болгохгүй ба одоогийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх бүрэн боломжтой болно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах	Үгүй	Хуулийн төсөлд энэ төрлийн харилцаанд хамаарах зохицуулалт тусгагдаагүй болно.

	зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийг баталснаар Монгол Улсын олон улсын гэрээтэй зөрчилдөхгүй болно.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө:

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь нийгэмд аливаа хэлбэрээр сөрөг үр нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Хүснэгт 5. Нийгэмд үзүүлэх үр нөлөө, тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Үгүй	Хуулийн төсөлд хөдөлмөрийн харилцааг зохицуулсан аливаа зохицуулалт тусгагдаагүй болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төсөлд шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгохтой холбогдсон аливаа зохицуулалт тусгагдаагүй болно.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл,	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

хэвлэл мэдээлэл, суртахуун ёс	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд аливаа хэлбэрээр сөрөг үр нөлөө үзүүлэхгүй болно.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар хуулийг албадан хэрэгжүүлэх нөхцөл байдал үүсэхгүй болно.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Хуулийн төслийг баталснаар гэмт хэргийн илрүүлэлт, цаашилбал шийдвэрлэлтэд тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэж байна.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар гэмт хэргийн хохирогч, гэрчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад тодорхой

			хэмжээнд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд аливаа хэлбэрээр сөрөг үр нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Хүснэгт 6. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, тайлбар

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа

			сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Үгүй	Хуулийн төслийг баталснаар аливаа сөрөг үр нөлөө гарахгүй болно.

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх:

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”⁹ гэж заасан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийг хэрэгжүүлэх)-ийн 7.2 дахь хэсэгт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:” гээд 7.2.4 дэх заалтад “... Хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх” гэж, мөн хуулийн 25 дугаар зүйл (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар Засгийн газрын бүрэн эрх)-ийн 25.1 дэх хэсэгт “Засгийн газар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” гээд 25.1.9 дэх заалтад “... Гэмт хэрэг, зөрчилтэй

⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэргэшсэн нэгж, мэргэжилтэн бэлтгэх”¹⁰ гэж тус тус заасан.

Эрүүгийн хуулийн 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суудаг харьяалалгүй хүн гадаад улсад энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдэж, тухайн гэмт хэрэгт нь эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй бол энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана.”¹¹ гэж заажээ.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.” гэж, 42.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх, прокурор, мөрдөгч нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ.”¹² гэж тус тус заасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2030 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.2.20-д “Хилийн чанад дахь Монгол Улсын иргэд гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллана” гэх зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлэхээр тусгасан.

Иймд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон дотоодын бусад хууль тогтоомжид нийцэж байгаагийн зэрэгцээ хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд аливаа хэлбэрээр сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан хүний эрхийн суурь зарчимд нийцэж байна гэж үзэж байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТУУДЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 7-д заасны дагуу “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарын эерэг болон сөрөг талуудыг:

- Зорилгод хүрэх байдал;

¹⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14700>

¹¹ <https://legalinfo.mn/mn/detail/11634>

¹² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн 5 үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд нягтлан шалгаж үзэхэд дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзлээ.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үндэстэн дамнасан аливаа төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэг нь аль нэг улсын гэмт бүлэглэлийн үйлдлийн арга, хэрэгслээр бусад оронд халдварлан хөгжих чиг хандлагатай болохыг салбарын мэргэжлийн эрдэмтэн судлаачид, практикт ажиллаж буй мэргэжилтнүүд үздэг ба Бүгд Найрамдах Чех Улсын тухайд Европ тивд түгээмэл үйлдэгддэг хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой болон хүн худалдаалах, садар самууныг сурталчлах зэрэг гэмт хэрэгтэй тэмцэх арвин туршлагатай улс юм.

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргүүдийг шийдвэрлэх, гэмт этгээд ял завших, дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох боломж бүрдэхийн зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагааг хоёр талд харилцан гүйцэтгэх, нотлох баримт бэхжүүлэх, хураан авах, эд мөрийн баримтаар тогтоох, зориулалтын орчин нөхцөлд хадгалах, харилцан солилцох боломж бий болох юм.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар:

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чадавх нэмэгдэх;
- Бүгд Найрамдах Чех Улс нь Европын Холбооны гишүүн улс бөгөөд тус улсын цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаандаа Европол (EUROPOL) нэгдсэн системийг ашигладаг бөгөөд энэхүү системээр дамжуулан Европын Холбооны улс орнуудад үйлдэгдэж буй гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэрийн мэдээллийг олж авах;
- Монгол Улсад гэмт хэрэг үйлдэн Европын Холбооны улсуудад оргон зайлсан гэмт этгээдүүдийг эрэн сурвалжлах, баривчлах, буцаан авчрах замаар ял завших, дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл боломжийг таслан зогсоох;
- Европын Холбооны улсуудад гэмт хэрэг үйлдэн Монгол Улсад оргон зайлсан этгээдүүдийг эрэн сурвалжлах, баривчлах, албадан гаргах замаар дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох;

- Шинэ төрлийн гэмт хэргийн үйлдлийг арга, зохион байгуулалтын хэлбэр зэргийн талаар мэдээлэл солилцож шуурхай таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх;

- Монгол Улсын иргэдийн зөрчигдсэн эрхийг сэргээх, хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхэд тодорхой хэмжээнд ахиц гаргах;

- Цагдаагийн алба хаагчид харилцан туршлага судлах, солилцох, суралцах замаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулиар хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжлийн мэдлэг ур чадварыг эзэмших, дээшлүүлэх;

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглахаар төлөвлөсөн, нэвтрүүлсэн дэвшилтэт техник, технологи, инновацийн талаар судалж үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мөн давуу болон сул талыг урьдчилан тогтоох, сэргийлэх боломжийг бий болгох юм.

Иймд “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлангаас дүгнэн үзэхэд энэхүү хуулийн төслийг баталснаар хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргүүдийг шийдвэрлэх, гэмт этгээдийн ял завших, дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг бэхжүүлэх, хураан авах, эд мөрийн баримтаар тогтоох, зориулалтын орчин нөхцөлд хадгалах, харилцан солилцох зэрэг арга хэлбэрээр дамжуулан иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлэх эрх зүйн орчныг бий болгоно гэж үзэж байна.

---oOo---



**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ**

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2026 он

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Агуулга

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл

Гурав. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

Дөрөв. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар иргэнд үүсэх зардлын тооцоо

Тав. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.1 дэх заалтад заасан анхдагч хуулийн төсөл бөгөөд мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэх журамтай.

Мөн энэхүү зардлын тооцоог гарган үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын² 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг³ баримтлах бөгөөд уг аргачлалын 1.5-д заасны дагуу хуулийн

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11993>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335&showType=1>

этгээдийн зардал, иргэний үүсэх зардал, төрийн байгууллагын зардал тус бүрийг тооцох юм.

Түүнчлэн “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталснаар уг хуулийг хэрэгжүүлэх хүрээнд улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл болон хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлангийн зорилго чиглэдэг тул дор энэ талаар авч үзнэ.

ХОЁР. “ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТАЛСНААР УЛСЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Манай улсын иргэдийн гадаад улсад зорчих тоо жил ирэх тусам тогтмол өсөж байгаатай холбоотойгоор гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, гэмт хэрэг, зөрчлийн улмаас хууль ёсны эрх ашиг нь зөрчигдөх явдал тодорхой хэмжээнд нэмэгдсээр байна.

Тухайлбал, сүүлийн гурван жилийн байдлаар манай улсын 260 мянга орчим иргэн хилийн чанадад ажил хөдөлмөр эрхлэх, суралцах зэрэг зорилгоор оршин сууж байгаагаас 2025 оны 12 дугаар сарын байдлаар манай улсын 14 200 орчим иргэн Бүгд Найрамдах Чех Улсад дээрх зорилгоор оршин сууж байна.⁴ Харин энэ оны 2 дугаар сарын байдлаар Бүгд Найрамдах Чех Улсын 36 иргэн манай улсад ажил хөдөлмөр эрхлэх, суралцах болон бусад зорилгоор оршин сууж байна.⁵

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тодорхой ажиллагааг хоёр улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх боломжтой болох бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломж бүрдэнэ.

Мөн хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргүүдийг шийдвэрлэх, гэмт этгээдийн ял завших, дахин гэмт хэрэг үйлдэх боломжийг таслан зогсоох, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид эрх зүйн

⁴ Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээлэл (2025 он, 2026 он)

⁵ Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээлэл (2026 оны 2 дугаар сар)

туслалцааны хүсэлт гаргах замаар гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар, мэдүүлэг авахын зэрэгцээ талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох боломжтой болох юм.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд буюу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд Чехийн талаас эрх зүйн туслалцааны хүсэлт ирүүлсэн тохиолдолд дээр дурдсан ажиллагааг Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд⁶ заасны дагуу эрх бүхий байгууллага тухайн жилийнхээ батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой байна.

Иймд эрх бүхий байгууллага хууль тогтоомжид заасны дагуу холбогдох ажиллагааг тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх учраас “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталснаар энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд улсын төсөвт шууд нэмэлт зардал шаардахгүй буюу улсын төсөвт нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байна.

**ГУРАВ. “ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТАЛСНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд эрх, үүрэг бий болгосон, мөн хуулийн этгээдийн хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зохицуулалт тусгагдаагүй тул хуулийн этгээдэд зардал үүсэхгүй байна. Иймд дээрх аргачлалд заасны дагуу дараагийн үе шатыг шалгах шаардлагагүй гэж үзлээ.

**ДӨРӨВ. “ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТАЛСНААР ИРГЭНД
ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд иргэнд эрх, үүрэг бий болгосон, мөн иргэний зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зохицуулалт тусгагдаагүй тул иргэнд зардал үүсэхгүй байна. Иймд дээрх аргачлалд заасны дагуу дараагийн үе шатыг шалгах шаардлагагүй гэж үзлээ.

⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

**ТАВ. “ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТАЛСНААР ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД
ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталснаар төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцох ажлыг дээр дурдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын⁷ 4.1-т заасны дагуу дараах үе шаттайгаар зохион байгуулахаар тусгасан. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- Гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Эдгээр үе шат нь дээрх хуулийн зохицуулалтаар төрийн байгууллагад шинээр эрх, үүрэг бий болгож байгаа тохиолдолд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын зүгээс нэмэлтээр зарцуулах мөнгөн зардал болон хугацааг тодорхойлоход чиглэгддэг болно.

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлохдоо тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох, байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох, чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах зарчмыг баримтлах шаардлагатай юм.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтын ажиллагааг хүсэлтийг үндэслэн хэрэгжүүлнэ. Энэхүү Хэлэлцээрт заасны дагуу мэдээлэл авах, хийх арга хэлбэр, маягт, хэрэгжүүлэх арга хэмжээ, эсхүл хамтын ажиллагааны бусад хэлбэрийн талаарх хүсэлтийг бичгээр үйлдэж хүргүүлнэ. Факс, цахим шуудан болон цахим харилцааны бусад хэрэгслээр дамжуулан гаргасан хүсэлтийг бичгээр үйлдэж хүргүүлсэн хүсэлтэд тооцно. Хэрэв хувийн мэдээллийг шилжүүлэх бол баталгаат мэдээлэл дамжуулах аргыг заавал сонгоно. Яаралтай тохиолдолд хүсэлтийг амаар гаргаж болох ба даруй бичгээр баталгаажуулж хүргүүлнэ.” гэж заасан.

Үүний дагуу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар, мэдүүлэг авахаас гадна талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335&showType=1>

нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох асуудлаар эрх зүйн туслалцааны хүсэлтийг гаргах боломжтой болох юм.

Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шатанд нөгөө талаас хүсэлт ирүүлсэн тохиолдолд мөрдөгч тухайн хүсэлтийг хүлээн авч танилцах, хүсэлтийн хүрээнд хийх ажиллагааг тодорхойлох, хүсэлтийг гүйцэтгэх, энэ талаар удирдлагад танилцуулах, хүсэлтийн хариуг хүргүүлэхээр албан бичгийн төсөл боловсруулах, албажуулах, хариуг нөгөө талдаа илгээх зэрэг ажиллагааг хийх тул үүнтэй холбогдуулан дараах тооцооллыг хийв. Үүнд:

Д/д	Ерөнхий стандарт үйл ажиллагаа	Хугацаа (минут)	Бичиг хэргийн зардал (төгрөг)
1.	Мөрдөгч хүсэлттэй танилцах	5	-
2.	Мөрдөгч хүсэлтийн хүрээнд хийгдэх ажиллагааг тодорхойлох	10	-
3.	Мөрдөгч тайлбар, мэдүүлэг өгөх тухайн этгээдтэй холбогдож, өдөр, цагийг мэдэгдэх	5	-
4.	Мөрдөгч тайлбар, мэдүүлэг авах (жишээлбэл 2 нүүр хуудас)	60	40 төгрөг + 2 төгрөг x 2 нүүр хуудас = 84 төгрөг
5.	Мөрдөгч авсан тайлбар, мэдүүлгийг тайлбар, мэдүүлэг өгсөн этгээдэд уншиж танилцуулан баталгаажуулах	20	-
6.	Мөрдөгч тайлбар, мэдүүлэг авсан талаараа удирдлагад танилцуулах	30	-
7.	Мөрдөгч хүсэлтийн гүйцэтгэлийн хариуг Бүгд Найрамдах Чех Улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх зорилгоор албан бичгийн төсөл боловсруулах (жишээлбэл 1 нүүр хуудас)	30	40 төгрөг + 2 төгрөг = 42 төгрөг
8.	Мөрдөгч хүсэлтийн гүйцэтгэлийн хариуг Бүгд Найрамдах Чех Улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх зорилгоор боловсруулсан албан бичгийн төслийг удирдлагад танилцуулах	10	
9.	Мөрдөгч хүсэлтийн гүйцэтгэлийн хариуг Бүгд Найрамдах Чех Улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх зорилгоор боловсруулсан албан бичгийн төслийг албажуулах, шууданд өгөх (жишээлбэл 1 нүүр хуудас)	15	40 төгрөг + 2 төгрөг = 42 төгрөг

10.	Хүсэлтийн гүйцэтгэлийн хариуг Бүгд Найрамдах Чех Улсын эрх бүхий байгууллагад хүргүүлэх шуудангийн зардал	-	300 гр = 17,600 төгрөг ⁸
Нэг хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, зардал		185 минут 185 минут х 155 төгрөг ⁹ = 28,675 төгрөг	17,768 төгрөг

Тайлбар: Бичгийн цаас¹⁰, принтерийн хорны¹¹ зардлаар тооцон гаргаав.

Чехийн талаас ирүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлтийн нийт тоог тодорхой гаргах боломжгүй ба хүсэлт хүлээн авсан тохиолдолд 1 хүсэлтийг гүйцэтгэхэд зарцуулах бичиг хэрэг болон шуудангийн дундаж зардалд 17,768 төгрөгийн зардал шаардагдах урьдчилсан тооцоолол гарч байна.

Мөн “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн дагуу Чехийн талын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн эрх зүйн туслалцааны хүсэлтийг гүйцэтгэхтэй холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагад шинээр ажлын байр бий болгохгүй, орон тоо нэмэхгүй учраас дээр дурдсан 28,675 төгрөгийн цалингийн зардал нэмж гарахгүй юм.

Харин хэлэлцээрт тусгасан ажлын уулзалт, хамтарсан сургалт, семинар, сургуулилт зэрэг бусад арга хэмжээг хамтран зохион байгуулах талаар талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр эдгээр арга хэмжээтэй холбогдон гарах зардлыг байгууллагынхаа тухайн жилийн төсөвт тусгах хэлбэрээр улсын төсөвт ачаалал үүсгэхгүйгээр шийдвэрлэх боломжтой гэж үзэж байна.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг баталснаар уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын¹² 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын¹³ дагуу үнэлж үзэхэд улсын төсөвт нөлөөлөл үзүүлэхгүй, шууд нэмэлт зардал үүсгэхгүй байна.

---oOo---

⁸ “Монгол шуудан” ХК-ийн гадаад шуудан илгээмжийн тарифаар тооцоолсон болно, <https://www.mongolpost.mn/price-calc>

⁹ Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоол, Төрийн тусгай албан тушаалын ТТ-7 зэрэглэлийн цалин 1,633,000 төгрөг, <https://leginfo.mn/mn/detail?lawId=17355342407681&showType=1>

¹⁰ А4-ийн хэмжээтэй 1 боодол бичгийн цаас (500 ширхэг), үнэ 19,180 төгрөг, <https://nomin.mn/p/1120708>

¹¹ Принтерийн хор (Bizhub 287), 230000 ширхэг нүүр хуудас хэвлэнэ, үнэ 270,000 төгрөг, <https://next.mn/mn/product/dr-2455-49bd>

¹² <https://leginfo.mn/mn/detail?lawId=11993>

¹³ <https://leginfo.mn/mn/detail?lawId=207335&showType=1>



**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ**

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2025 он

**“ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛС ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

Агуулга

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт

Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх эсэхээ тогтоосон байдал

Дөрөв. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

Тав. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн 22.1.1 дэх заалтад заасан анхдагч хуулийн төсөл бөгөөд мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төсөлд дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцох, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах зорилгоор хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг хийж гүйцэтгэлээ.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх энэхүү судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дугаар тогтоолын² 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д³ заасны дагуу дараах үе шатаар хийж гүйцэтгэв. Үүнд:

¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11993>

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207335&showType=1>

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох эсэхээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх энэхүү судалгааг хийж гүйцэтгэхдээ “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн зорилго, хамрах хүрээ, уг хэлэлцээрээр зохицуулах харилцаа зэрэгтэй уялдуулан дээр дурдсан аргачлалд заасны дагуу дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгож авав. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн хуулийн төслийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгын үүднээс уг шалгуур үзүүлэлтийг сонгож авав.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Их Хурлаас соёрхон батлах энэхүү хэлэлцээрт туссан дараах зохицуулалтуудын практикт хэрэгжих боломжийг шалгах зорилгын үүднээс сонгож авлаа. Үүнд:

- Хэлэлцээрээр зохицуулсан талуудын хамтран ажиллах, тэмцэх, урьдчилан сэргийлэх гэмт хэргийн төрөл, хэлбэр болон талуудын хамтын ажиллагааны чиглэл нь сүүлийн жилүүдэд олон улсын түвшинд болон бүс нутгийн хэмжээнд гарч буй хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд тодорхой хэмжээнд ахиц гарахад нөлөө үзүүлэх эсэхийг үнэлэх;
- Хэлэлцээрт туссан зохицуулалтууд хэлэлцэн тохирогч талуудын дотоодын хууль тогтоомж, нэгдэн орсон бусад олон улсын олон талт гэрээ, конвенц болон талуудын бусад улс орнуудтай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцсэн эсэхийг үнэлэх;

- Хэлэлцээрийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид түргэн, шуурхай хамтран ажиллах боломжтой эсэхийг үнэлэх;
- Хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохирогч талуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах, мөн хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэлтэй танилцах, харилцан дамжуулах, солилцох, түүнийг хадгалах, хамгаалахтай холбогдох зохицуулалтыг үнэлэх;
- Хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохирогч талууд хүний хувийн мэдээллийг авахаар нөгөө талдаа хүсэлт гаргах, хүсэлтийн дагуу тухайн мэдээллийг шилжүүлэх, мэдээллийг хүлээн авсан талын мэдээллийг бүртгэх, ашиглах, хамгаалах устгах арга хэлбэрийн талаарх зохицуулалтыг үнэлэх.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн зохицуулалтыг уг хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдэд ойлгомжтой байхаар, мөн монгол хэлний хэл зүйн болон найруулгын хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулсан эсэхийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагын дагуу үнэлэхийг удирдлага болгов.

Харин “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасан 6 шалгуур үзүүлэлтээс “хүлээн зөвшөөрөгдөх байдал” болон “зардал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг энэхүү үнэлгээнд сонгож аваагүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр” болон уг хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхэд харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төсөл нь “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд дэвшүүлсэн талуудын хамтын ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох зорилгоор дараах зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад хэлэлцэн тохирогч талууд идэвхтэй хамтран ажиллах;
2. Зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд онцгойлон анхаарахын зэрэгцээ энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах.

Дээр дурдсан зорилгыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үнэлэхэд:

Зорилт 1. Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад хэлэлцэн тохирогч талуудын холбогдох эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцах замаар шуурхай арга хэмжээ авах хүрээнд:

Манай улсын дотоодын хууль тогтоомжид зохицуулснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд гэмт хэрэгт ач холбогдол бүхий мэдээ мэдээлэл, холбогдох баримт бичиг зэргийг харилцан солилцох ажиллагааг эрх зүйн харилцан туслалцааны нэг хэлбэр болгон авч үзсэн төдийгүй энэхүү хүсэлтийг айлын талд илгээхдээ хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улмаар дипломат шугамаар дамжуулахаар тусгасан.

Харин эрх бүхий байгууллагуудын тухайд гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтооход түргэн шуурхай хариу арга хэмжээ авч байх хэрэгцээ шаардлагын үүднээс хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид өөр хоорондоо шууд харилцах замаар хамтран ажиллах боломжийн талаар хэлэлцээрт хэрхэн тусгаж, зохицуулсан болохыг үнэлгээ хийх үүднээс сонгосон болно.

Зорилт 2. Зохион байгуулалттай гэмт хэрэгт онцгойлон анхаарахын зэрэгцээ ялангуяа хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, терроризм, түүнийг санхүүжүүлэх, хүн худалдаалахтай холбоотой, мөн цахим орчинд үйлдэгдэж буй хууль бус мөрийтэй тоглоом, залилан мэхлэх, садар самууныг сурталчлахтай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах хүрээнд:

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 238, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 388 бүртгэгдсэн⁴ нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд тухайн төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох

⁴ “Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” товхимол (2022 он, 2023 он).

чиглэлээр бүс нутгийн төдийгүй олон улсын цагдаа, хууль сахиулах байгууллагуудтай түргэн, шуурхай хамтран ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгож байгаа тул энэ төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх талаарх зохицуулалтыг хэлэлцээрт хэрхэн тусгасан болохыг үнэлгээ хийх үүднээс сонгосон болно.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв. Үүнд:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалтууд	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийх, сонгосон зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой эсэхийг тодорхойлох.
2	Практикт хэрэглэх боломж	Хэлэлцээрийн 1-8 дугаар зүйл, 17, 18, 27, 29 дүгээр зүйл болон хэлэлцээрийн Хавсралт	Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх, дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зарим хэсэг	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар

			хуулийн төслийн уялдааг тодорхойлох.
--	--	--	--------------------------------------

Дээрх шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв. Үүнд:

1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Зорилт 1. *Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг олж тогтоох, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулахад хэлэлцэн тохирогч талуудын холбогдох эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцах замаар шуурхай арга хэмжээ авах талаар үнэлгээ хийсэн нь:*

Хэлэлцээрийн гол зорилго, талуудын хамтран тэмцэх, урьдчилан сэргийлэх зохион байгуулалттай гэмт хэргийн төрөл, хэлбэрийг тодорхойлохын зэрэгцээ уг хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой юм.

Түүнчлэн энэхүү хэлэлцээрээр дамжуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах замаар гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар, мэдүүлэг авахаас гадна талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох боломжтой болж байгаа юм.

Зорилт 2. *Зохион байгуулалттай гэмт хэрэгт онцгойлон анхаарахын зэрэгцээ ялангуяа хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, терроризм, түүнийг санхүүжүүлэх, хүн худалдаалахтай холбоотой, мөн цахим орчинд үйлдэгдэж буй хууль бус мөрийтэй тоглоом, залилан мэхлэх, садар самууныг сурталчлахтай холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллах талаар үнэлгээ хийсэн нь:*

Хэлэлцээрийн хүрээнд талуудын эрх бүхий байгууллагууд зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн зохион байгуулагч, тэдгээрийн холбоо хамаарал, бүтэц, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан арга техник, мөн террорист бүлэглэл, тэдгээрийн үйлдсэн гэмт хэрэг, цогцост шүүх шинжилгээний байгууллагаас хийсэн үзлэг, шинжилгээний дүгнэлт, криминологийн судалгаа, мөрдөн шалгах ажиллагааны арга тактик, түүнчлэн талуудын нутаг дэвсгэрт хилээр нэвтрэхдээ ашигласан бичиг баримт, оршин байгаа газар гэх зэрэг мэдээлэл, цагдаагийн байгууллагын бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг харилцан солилцохоос

гадна талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгч ажиллах чиг үүрэг бүхий офицер, зөвлөх гэх мэргэжилтнүүдийг харилцан илгээхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Тухайлбал, хэлэлцээрийн хүрээнд талууд дараах төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцжээ. Үүнд:

- (a) Бусдын амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, алдар хүндийн эсрэг;
- (b) Терроризм, түүнийг санхүүжүүлэх;
- (c) Хүн худалдаалах, биеэ үнэлүүлэх, зуучлах, түүнчлэн хүний эд, эрхтэнийг худалдаалах;
- (d) Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл болон хүүхэд ашигласан порнограф;
- (e) Хэт даврах, арьс үндсээр алагчилах болон хэт үндсэрхэг үзэл гаргах;
- (f) 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц”-д заасан мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, тэр дундаа тэдгээрийн угтвар бодисын хууль бус эргэлт;
- (g) Галт зэвсэг, зэвсгийн шинж чанартай зүйл, сум, тэсрэх бодис, тэсрэх төхөөрөмж, химийн, биологийн, цацраг идэвхт бодис болон цөмийн материалыг, мөн стратегийн ач холбогдол бүхий бараа, технологи болон цэргийн эд зүйл, хэрэгсэл, түүнчлэн онц аюултай бусад төрлийн бодис болон аюултай хог хаягдлыг хууль бусаар үйлдвэрлэх, зуучлах, эзэмших, импортлох, экспортлох, дамжин тээвэрлэх болон худалдаалах;
- (h) Мөнгө угаах гэмт хэрэг;
- (i) Цахим гэмт хэрэг;
- (j) Өмчийн эсрэг гэмт хэрэг, тухайлбал залилах, хулгайлах, тээврийн хэрэгслийг бусад хууль бус хэлбэрээр ашиглах;
- (k) Мөнгөн тэмдэгт, тэмдэг, үнэт цаас, бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болон албан баримт бичиг, ялангуяа гадаад паспорт хуурамчаар үйлдэх, өөрчлөх, нийлүүлэх, ашиглах;
- (l) Оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг;
- (m) Эдийн засгийн бусад ноцтой гэмт хэрэг;
- (n) Соёлын болон түүхийн үнэт зүйлийн эсрэг гэмт хэрэг;
- (o) Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, ялангуяа ховор, нэн ховор ургамал, амьтан, түүний төрөл зүйлийг хууль бусаар худалдах.

Мөн хэлэлцэн тохирогч талуудын хамтын ажиллагааны тусгай хэлбэрүүд буюу тусгай хамгаалалт шаардагдах аливаа этгээдийг хамгаалах, тээвэрлэх, хилээр нэвтрүүлэх, уг этгээдэд холбогдох бүхий л төрлийн мэдээллийг харилцан солилцох, түүнчлэн талууд “Гамшгийн үеийн хохирогчийг тодорхойлох баг”-ийг томилох замаар тодорхой төрлийн ажиллагааг гүйцэтгүүлэхээр хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт илгээх тухай асуудлыг хэлэлцээрт мөн зохицуулсан байна.

2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

1) *Хэлэлцээрээр зохицуулсан талуудын хамтран ажиллах, тэмцэх, урьдчилан сэргийлэх гэмт хэргийн төрөл, хэлбэр болон талуудын хамтын ажиллагааны чиглэл нь сүүлийн жилүүдэд олон улсын түвшинд болон бүс нутгийн хэмжээнд гарч буй хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд тодорхой хэмжээнд ахиц гарахад нөлөө үзүүлэх эсэх талаарх үнэлгээ:*

Дэлхийн улс орнууд даяаршиж, нэгдмэл болохын хэрээр аюул занал ч мөн нийтлэг шинж чанартай болж байгаатай холбогдуулан ихэнх улс орон бүс нутгийн аюулгүй байдлыг хамтран хамгаалах тогтолцоог бий болгоход илүүтэй анхаарч байна.

Гадаад улс орнуудад үндэстэн дамнасан зохион байгуулалттай, нууц, далд аргаар үйлдэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн үйлдлийн арга, зохион байгуулалтын хэлбэрийг илрүүлэх, таслан зогсооход хүндрэл учирч байгаагийн зэрэгцээ нэг улсын хил хязгаараас давж, улс орон дамжин үйлдэгдэх хандлага нэмэгдэж байгаа нь хэд хэдэн улсын цагдаагийн байгууллага хамтран гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хэрэгцээ, шаардлага бий болсоор байна.

Мөн манай улсын иргэдийн гадаад улсад зорчих тоо жил ирэх тусам өсөж байгаатай холбоотойгоор гадаад улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдох, түүнчлэн гэмт хэрэг, зөрчлийн улмаас хууль ёсны эрх ашиг нь хөндөгдөх, аливаа хэлбэрээр эд хөрөнгөд нь хохирол учрах явдал нэмэгдсээр байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 238, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 388 бүртгэгдсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд тухайн төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр бүс нутгийн төдийгүй олон улсын цагдаа, хууль сахиулах байгууллагуудтай түргэн, шуурхай хамтран ажиллах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Мөн цахим орчинд үйлдэгдэж буй хууль бус мөрийтэй тоглоом, залилан мэхлэх, садар самууныг сурталчлах, хүн худалдаалах зэрэг гэмт хэргүүд зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, энэ төрлийн гэмт хэргийн гаралт, насанд хүрээгүй хохирогчдын тоо жил бүр өсөн нэмэгдэж байгаагийн зэрэгцээ зүүн Европын орнууд болох Албани, Серби зэрэг улсын гэмт бүлэглэлүүдийн үйлдлийн арга, хэлбэртэй төстэйгээр үйлдэгдэж байгаа нь Чех Улстай энэ чиглэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгцээг илэрхийлж байгаа юм.

Иймд “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Чех Улсаар

дамжин Европын холбооны 27 улсад ажиллаж, амьдарч буй Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүднээс шуурхай мэдээлэл солилцох, хамтран ажиллахад чухал ач холбогдолтой хэлэлцээр гэж үзэж байна.

2) *Хэлэлцээрт туссан зохицуулалтууд хэлэлцэн тохирогч талуудын дотоодын хууль тогтоомж, нэгдэн орсон бусад олон улсын олон талт гэрээ, конвенц болон талуудын бусад улс орнуудтай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцсэн эсэх талаарх үнэлгээ:*

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ээр зохицуулсан харилцаа, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

Мөн талууд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризмтой үр нөлөөтэй тэмцэхийг зорьж байгаагийн зэрэгцээ 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан бөгөөд хэлэлцэн тохирогч талуудын нэгдэн орсон “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц” болон түүний Протоколуудыг харгалзан үзэхээ илэрхийлжээ.

Түүнчлэн энэхүү хэлэлцээрт талуудын нэгдэн орсон бусад олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, үндэсний хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбогдох зохицуулалтыг тусгасан бөгөөд уг хэлэлцээрийн 27 дугаар зүйлд “Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын заавал дагаж мөрдөх олон улсын бусад хоёр талт болон олон талт гэрээгээр хүлээсэн үүргийг хөндөхгүй” гэж зохицуулсан байна.

3) *Хэлэлцээрийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид түргэн, шуурхай хамтран ажиллах боломжтой эсэх талаарх үнэлгээ:*

Хэлэлцээрийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын цагдаагийн байгууллагын мөрдөгчид эрх зүйн туслалцааны хүсэлт гаргах замаар гэрч, шинжээч, сэжигтэн, яллагдагч болон бусад этгээдээс тайлбар, мэдүүлэг авахын зэрэгцээ талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцад хамаарах баримт бичиг, мэдээлэл, нотлох баримтыг харилцан солилцох боломжтой юм.

Мөн эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тодорхой ажиллагааг Чех Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх боломжтой болох бөгөөд энэ нь эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх, өөрийн улсын иргэд, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хангах нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,

илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Түүнчлэн талууд хэлэлцээрийн хүрээнд өөр хоорондоо харилцах эрх бүхий байгууллагыг харилцан томилохоор зохицуулсан ба энэ талаар хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хамтран ажиллах эрх бүхий байгууллагуудын талаар харилцан бие биедээ дипломат шугамаар мэдэгдэнэ. Ингэхдээ эрх бүхий байгууллагуудын холбоо барих хаяг, утас, факсын дугаар, эсхүл өөр бусад харилцах мэдээллийг мэдэгдэнэ” гэж заажээ.

Дээр дурдсанаас гадна талууд хэлэлцээрийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс шаардлагатай тохиолдолд тусгайлсан тохиролцоо хийх боломжийн талаар хэлэлцээрт зохицуулсан бөгөөд энэ талаар хэлэлцээрийн 25 дугаар зүйлд “Хэлэлцэн тохирогч Талуудын Засгийн газар, цаашилбал Монголын талаас Хууль зүй, дотоод хэргийн яам, Чехийн талаас Дотоод хэргийн яам болон Сангийн яам шаардлагатай тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжилтийн тохиролцоо байгуулж болно” гэж тусгасан байна.

4) Хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохирогч талууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах бөгөөд хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэлтэй танилцах, харилцан дамжуулах, солилцох, түүнийг хадгалах, хамгаалахтай холбогдох зохицуулалтын талаарх үнэлгээ:

Хэлэлцэн тохирогч Талууд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах, мөн хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэлтэй танилцах, харилцан дамжуулах, солилцох, түүнийг хадгалах, хамгаалахдаа дотоодын хууль тогтоомжийг баримтлахаар зохицуулсан.

Тухайлбал, манай улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, түүнчлэн Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам” болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан зохицуулалтыг дагаж мөрдөх юм.

Түүнчлэн хэлэлцээрийн 18 дугаар зүйлд нууц мэдээллийг шилжүүлэх, харилцан хамгаалахтай холбогдох харилцааг дэлгэрүүлэн зохицуулж өгсөн бөгөөд уг хэлэлцээрийн Хавсралт хэсэгт талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу тогтоосон нууцын ангилал, зэрэглэлийг дүйцүүлэн заасан ба талууд харилцан мэдээлэл солилцохдоо тухайн хавсралтад заасан нууцын зэрэглэлийг илэрхийлсэн тэмдэглэгээг хэрэглэх тухай асуудлыг тусгасан байна.

5) *Хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохирогч талууд хүний хувийн мэдээллийг авахаар нөгөө талдаа хүсэлт гаргах, хүсэлтийн дагуу мэдээллийг шилжүүлэх, мэдээллийг хүлээн авсан талын мэдээллийг бүртгэх, ашиглах, хамгаалах устгах арга хэлбэрийн талаарх зохицуулалтын талаарх үнэлгээ:*

Хэлэлцэн тохирогч Талууд хүний хувийн мэдээллийг авах, авахаар хүсэлт гаргах, улмаар энэхүү хүсэлтийг үндэслэн тухайн мэдээллийг нөгөө талд шилжүүлэх, мөн мэдээллийг хүлээн авсан тал уг мэдээллийг бүртгэх, ашиглах, хамгаалахдаа дотоодынхоо хууль тогтоомжийг баримтлахаар зохицуулсан.

Тухайлбал, манай улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан зохицуулалтыг дагаж мөрдөх юм.

Мөн хэлэлцээрийн 4 дүгээр хэсэгт талуудын хувийн мэдээллийг авахаар нөгөө талдаа хүсэлт гаргах, хүсэлтийн дагуу мэдээллийг шилжүүлэх, мэдээллийг хүлээн авсан тал тухайн мэдээллийг бүртгэх, ашиглах, хамгаалах устгах арга хэлбэрийг тодорхойлсон ба хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн (а) хэсэгт "... хувийн мэдээллийг энэхүү Хэлэлцээрийн хүрээнд зөвшөөрөх бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөн олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талаас тавьсан нөхцөлийн дагуу ашиглана" гэж зохицуулжээ.

Түүнчлэн хувийн мэдээллийг шилжүүлэн өгсөн талын хүсэлтээр уг мэдээллийг хүлээн авсан тал тухайн мэдээллээ хэрхэн ашигласан талаар болон түүнийг ашигласнаар гарсан үр дүнгийн талаар нөгөө талд мэдээллэх тухай зохицуулалтыг мөн тусгаж өгсөн байна.

3. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

"Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасанчлан нийгмийн тодорхой төрлийн харилцааг шинэ хуулиар зохицуулж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Дээрх хэлэлцээр нь 5 хэсэг, 29 зүйл, хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад

нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах асуултад хариулт өгөх замаар шалгаж үзлээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх	Шаардлага хангасан
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	Шаардлага хангасан
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Шаардлага хангасан
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Шаардлага хангасан
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Шаардлага хангасан
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Шаардлага хангасан
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Шаардлага хангасан
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх	Шаардлага хангасан
29.2.Хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох, зарим үг, өгүүлбэр, тоо, тэмдэгт хасах талаар тусгана	Шаардлага хангасан
29.3.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна	Шаардлагагүй

29.4.Энэ хуулийн 14.5-д зааснаас бусад хуулийн төслийг дагалдуулан анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлэхийг хориглоно	Шаардлагагүй
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх	Шаардлага хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх	Шаардлага хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих	Шаардлага хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх	Шаардлага хангасан

4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасны дагуу хуулийн төслийн уялдаа холбоог дараах асуултад хариулт өгөх замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгалаа.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан хуулийн төслийн уялдаа холбоог тогтооход тавих нийтлэг шаардлага	
<i>Шаардлага</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм
4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	-
4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм
4.10.4.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм
4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй
4.10.6.хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм
4.10.7.хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй
4.10.8.хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй

4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй
4.10.10.татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон асуудал тусгагдаагүй болно.
4.10.11.тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал тусгагдаагүй болно.
4.10.12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй
4.10.13.хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөлд жөндөрийн эрх тэгш байдлын талаарх асуудал тусгагдаагүй болно.
4.10.14.хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
4.10.15.хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
4.10.16.хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Үгүй

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх энэхүү үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт:

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг сонгон авсан шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлгээг нэгтгэж, дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

- Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон зорилго, зорилтыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг илэрхийлж чадахуйц, бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийж үзэхэд зорилго, зорилтыг хангахад чиглэсэн зохицуулалтууд нь зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдсон байна.
- Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан байна. Тухайлбал, “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг үнэлж үзэхэд зохион байгуулалттай, тэр дундаа хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, терроризм, түүнийг санхүүжүүлэх, хүн худалдаалахтай холбоотой, мөн цахим орчинд үйлдэгдэж буй хууль бус мөрийтэй тоглоом, залилан мэхлэх зэрэг гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр талууд шууд харилцах замаар бодитой хамтран ажиллах эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгсөн нь энэхүү шаардлагыг хангасан байна.
- “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг үнэлж үзэхэд талуудын хил дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тодорхой хэмжээнд ахиц гарахад нөлөө үзүүлэхүйц, мөн талуудын нэгдэн орсон бусад олон улсын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэгт үл харшлах, түүнчлэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцах боломжтой байхаар хэлэлцээрт тусгаж өгсний зэрэгцээ хуулиар хамгаалагдсан нууц мэдээлэл болон хүний хувийн мэдээллийг хүлээн авах, ашиглах, хадгалах, хамгаалах зэрэгт холбогдох асуудлыг зохицуулахдаа практикт хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж өгсөн нь энэхүү шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.
- “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг үнэлж үзэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна.
- “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан бөгөөд аргачлалд заасан шаардлагыг мөн хангасан болно.

---oOo---

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДИЙН НЭРС

1. С.Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн сайд
2. Д.Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
3. Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга
4. Ч.Нарантуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын
гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга
5. Х.Дөлгөөн Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын
гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын шинжээч
6. Б.Дэлгэрсайхан Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга,
цагдаагийн хурандаа
7. П.Батбаатар Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны
удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа
8. Б.Эрдэнэдалай Цагдаагийн ерөнхий газрын Гадаад харилцаа,
энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга,
цагдаагийн хурандаа

---oOo---